

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 8 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 8 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг

	Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
	Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 5
	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6 - 42
1.	“Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	8 - 28
2.	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/	28-42

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 8 дугаар сарын 28-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 48 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Э.Бат-Амгалан, Х.Баасанжаргал, Б.Бат-Эрдэнэ, Л.Мөнхбаатар, М.Нарантуяа-Нара, С.Одонтуяа;
Тасалсан: Н.Алтанхуяг, Х.Баттулга.*

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг “хэлэлцэх асуудлын дараалалд орсон хоёр дахь асуудлыг эхэлж хэлэлцье” гэсэн горимын санал гаргав.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд санал хэлэв.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

***Нэг. “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлөх тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн А.Насандэлгэр, Н.Отгончимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

“Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Г.Уянгахишиг, П.Сайнзориг, О.Номинчимэг, С.Эрдэнэболд, Б.Энхбаяр, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Отгончимэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Г.Уянгахишиг, Б.Заяабал, Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Наранчулууны Отгончимэгийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 7

Бүгд: 12

41.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Улсын ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасаням, Цагдаагийн ерөнхий газрын дарга Т.Сүхболд, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, мөн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Б.Өүлэн-Үжин, Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, мөн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Х.Цогтбаатар, Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын дэд дарга Э.Халиунбаяр, мөн газрын Санхүү, хангамжийн газрын дарга Х.Саранчимэг, Гадаадын иргэн, харьяатын газрын Захиргаа, удирдлагын газрын дарга И.Баатархүү, Оюуны өмчийн газрын Захиргаа, удирдлагын газрын дарга А.Мөнхтөр, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны дарга Д.Батчулуун, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Нарийн бичгийн дарга Г.Төгөлдөр, Хил хамгаалах ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чойжилсүрэн, мөн газрын Ар тал, зэвсэглэл, инженер техник эрхэлсэн дэд дарга Б.Батхүү, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Санхүү, үйлдвэр хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Нямгомбо, мөн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Т.Өнөртуяа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн С.Анхзаяа, Ч.Цэдэндорж, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын аудитын менежер Ю.Энхтуяа, мөн газрын ахлах аудитор П.Амарсанаа, У.Оюунхүү, аудитор Б.Идэрбалжинням, Д.Нямжаргал, мөн газрын аудитын менежер Б.Долгорсүрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранбилэг, Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга Д.Мөнхзориг, мөн хорооны ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал, Хүний эрхийн Үндэсний Комиссын Санхүү, хөрөнгө оруулалтын тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч Б.Бадамсэрээжид, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч Б.Гантулга, мөн газрын шинжээч Б.Болормаа, Улсын ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газрын төсвийн мэргэжилтэн Д.Занданхүү, Авлигатай тэмцэх газрын ерөнхий нягтлан бодогч Т.Цэрмаа, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албаны дарга Л.Очирсүрэн, мөн комиссын ерөнхий нягтлан бодогч Х.Хажидмаа, Оюуны өмчийн газрын ерөнхий нягтлан бодогч Д.Отгонсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Улсын ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар үг хэлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 17 минут үргэлжилж, 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр 14 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 8 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
11 цаг 48 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Өнөөдрийн Хууль зүйн байнгын хорооныхоо хурлыг эхлүүлье.

Хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг эрье.

Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хуралдаанд ирсэн гишүүд Дамдины Цогтбаатар, Дашдондогийн Ганбат, Батжаргалын Заяабал, Одсүрэнгийн Номинчимэг, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Баттөмөрийн Энхбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүдийн ирцтэйгээр ирц 54.5 хувь хувиар бүрдсэн байна. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаа танилцуулъя.

Өнөөдөр бол 2 асуудал хэлэлцэхээр байгаа.

Нэг нь, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Засгийн газар 2024 оны 8 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн байгаа.

Хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд бид хэлэлцээд хүргүүлэх ёстой.

Хоёрдугаар асуудал. “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл байгаа.

Ингээд хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү.

С.Эрдэнэболд гишүүн, Г.Уянгахишиг гишүүн. С.Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Г.Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Хэлэлцэх асуудлын дараалал дээр одоо нөгөө гүйцэтгэл хэлэлцэхээр чинь бид нар нэлээн удна шүү дээ.

Тэгэхээр хоёр дахь асуудлыг нь эхлээд хэлэлцэх боломж байдаг юм болов уу? Хэрвээ хүмүүс нь ирсэн бол. Тийм.

Д.Цогтбаатар: Тэр бол болохгүй гэх юм байхгүй.

Тэгвэл та энэ дээр горимын санал гаргаад хэдүүлээ санал хураачих уу? Тэгээд дэс дарааг нь өөрчлөөд л явчихъя.

Нэгэнт би үүгээр би уншчихлаа шүү дээ. Тийм. Энэ чинь нөгөө даргын дэргэдэх зөвлөлөөр би ийм дэс дарааллаар хэлэлцүүлнэ гээд оруулчихсан байж байгаа учраас Байнгын хорооны гишүүдийн бүрэн эрхийн асуудал шүү дээ.

Та тэгвэл горимын санал гаргачих. Тэгье тэгье. Зөв байх.

Г.Уянгахишиг: Горимын санал гаргаж байна.

Тэгэхээр хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулах буюу хоёр дахь асуудлыг эхлээд хэлэлцье гэдэг санал гаргаж байна.

Д.Цогтбаатар: Тэгвэл Г.Уянгахишиг гишүүний горимын саналаар.

С.Эрдэнэболд гишүүн эхлээд үгээ хэлчих бас. С.Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Бид чинь бараг 4 долоо хоног. Сарын өмнө шахуу Хүний эрхийн дэд хорооны хурал хийсэн.

Тэгээд тэр хурал дээрээс 21 хоногийн хугацаатай даалгавруудыг 5 байгууллага руу өгчихсөн байгаа. Тэр хугацаа нь өнгөрчихсөн яваад байгаа.

Тухайн үед Х.Тэмүүжин гишүүн буюу хамгийн ахмад нь таныг эзгүйд даргалаад хурлаа хийчихсэн.

Тэгээд тэр хугацаа өнгөрөөд яваад байдаг. Тухайн үед 21 настай залуугийн асуудал гээд явчихсан байгаа шүү дээ.

Тэгэхээр үүнийг эргээд энэ Байнгын хорооны хэлэлцэх асуудал руу. Өнөөдөр биш юм аа гэхэд зүгээр нэг тов гаргах.

Хоёрдугаарт, Хүний эрхийн дэд хороотой холбоотой нөгөө зохион байгуулалтын асуудлуудыг бүлгүүд хүлээгдээд байгаа.

Үүнийгээ нэг жигдрүүлээд явахгүй бол Хууль зүйн байнгын хорооны бас нэг чухал дэд хорооных нь ажил жоохон хойшлогдоод байгаа юм шиг байна.

Тэгээд үүнийг бас хэлэлцэх асуудал дээрээ оруулаад ч юм уу, эсвэл оруулах боломжгүй байдаг юм бол энэ дээр дарга нэг шийдэл гаргаач ээ гэсэн хүсэлт байгаа юм.

Д.Цогтбаатар: Тэгье тэгье. Би энэ Байнгын хорооныхонд чиглэл өгч байна.

Саяын энэ хөндсөн асуудлаар бид хаана хаана ямар байгууллагууд. Өөрсдийнхөө санал, дүгнэлтүүдийг ирүүлж байх ёстой шүү дээ.

Тэгээд хугацаатай ирүүлсэн. Хууль зүйн байнгын хороо болон Хүний эрхийн дэд хорооноос өгч байгаа чиглэлийг хүндэтгэж байх ёстой. Төрийн байгууллагууд.

Тэгэхээр бид хурлынхаа хугацааг 11 сар луу хойшлуулж шилжүүлсэн байгаа шүү дээ. Нөгөө журам батлагдаагүй байгаа учраас. Тийм. Сонголын. Яг энэ дагуу гарсан үндсэн гол шийдвэр бол сонгогч явуулъя гэж байгаа шүү дээ.

Тэгэхээр түүнтэй холбогдуулаад Байнгын хорооны зүгээс жишээлбэл Байнгын хорооны даргын зүгээс юу гаргасан байгаа гэхээр Их Хурлын Тамгын газарт. Тэр журмаас болоод бид хугацааг хойшлуулсан шүү дээ.

Журмыг яаралтай гаргах энэ хугацаанд яг багтааж энэ бүх юмнуудаа хийх ёстой шүү гэдэг юуг өгчихсөн байж байгаа. Албан тоотыг.

Нөгөө талаасаа харин бусад байгууллагууд ер нь ажил нь хэр явж байна. Энэ танилцуулга юмнуудаа ирүүлж байна уу? Үүнийг лавлаад С.Эрдэнэболд гишүүнд бас өгөх хэрэгтэй.

Бас надад энэ дээр цаашдаа бид энэ явцын талаар яаж хянаж дүгнэж байх вэ. Энэ танилцуулгыг надаа хийх хэрэгтэй гэж чиглэл өгч байна.

Гол юм нь яг хэлэлцэх асуудалд оруулах эсэхийг бол би энэ явцыг сонсож байж тэр шийдвэрээ гаргая.

Ингээд Г.Уянгахишиг гишүүний саналаар санал хураалт явуулъя.

75.0 хувиар санал дэмжигдлээ.

Тиймээс хэлэлцэх асуудлын дэс дараа өөрчлөгдлөө.

Нэгдүгээр асуудал. “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан гишүүд саналаа хэлж дууслаа. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа орё.

Нэг. “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

“Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн Наранчулууны Отгончимэг үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргасан

тухай албан бичгийг ирүүлсэнтэй холбогдуулан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл орж ирсэн байгаа. Үүнийг хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хуралдаанд Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Амгалангийн Насандэлгэр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Наранчулууны Отгончимэг ирж оролцож байна.

Энэ асуудалтай холбогдуулан тогтоолын төслийг Та бүгдэд бол тараасан байгаа.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

П.Сайнзориг гишүүнээр тасаллаа.
Д.Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Өглөөний мэнд.

Манай Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн чинь билээ. Энэ чинь шүүгч гишүүд гэж байгаа, шүүгч бус гишүүд гээд.

Улсын Их Хурлаар 6 жилийн хугацаатай томилогдоод явдаг л даа. 4 жилийн хугацаатай томилогдоод явдаг. Тэр хэвээрээ байгаа байх гэж ойлгож байна.

Таны бүрэн эрх чинь ямар хугацаагаар хэрэгжээд, энэ хугацаанд ямаршуухан ажиллав гэсэн ийм нэг асуулт байх юм.

Хүн ажлаас гарч болно, орж болно. Өөрийн хүсэлтээр гэсэн байна.

Гараад хувийн хэвшилд ч юм уу, бас эмчилгээ энэ тэр хөөцөлдөх гэж байгаа бол бас тэр хүний хувийн л асуудал байх л даа.

Ямар нэгэн байдлаар төрийн байгууллагад ч юм уу, бас өөр газар, энэ

дотроо хууль шүүхийн газар шилжиж ажиллах гэж байна уу, дэвшээд явж байгаа юм уу? Ямар байгаа юм бол.

Ийм байвал ямар учир шалтгаан байдаг юм гэсэн ийм асуулт байна.

Ер нь тэнд тогтвортой л ажиллуулах зорилготой байгаа юм л даа. Бид бол.

Шүүхийн хараат бус байдал гэж байна.

Шүүхийг сайн ажиллуулахын тулд сайн боловсон хүчнийг, ялангуяа Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчдийг сонгон шалгаруулдаг.

Энэ дээр нэлээн мэргэшсэн, одоо 2 жил ажиллачихсан байгаа болов уу. Өөрөө хэдэн жил ажиллачихсан байна. 3 жил ч байна уу.

Тэгээд энэ бүрэн эрхээ дуусгаад ингээд явж байгаа.

Юу нь болохоо байчихсан юм бол. Хувийн энэ тэр юм байхгүй бол. Тэр шалтаг шалтгаанаа нэг их хувийн нууцад нь хамаарахгүй бол хариулж болох уу л гэж байгаа юм. Тийм.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон өгье.

Хариулахаас өмнө. Энэ 5 дугаар микрофоны цагийг түр зогсоож байгаарай.

Хариулахаас өмнө нэг юм хэлчихье. Би энд хариулах боломжийг ямар үндэслэлээр олгож байгаа гэхээр Д.Ганбат гишүүн сая яг зөв асуулаа.

Өөрөөр хэлбэл хувийн нууцад чинь хамаарахгүй байгаа бол та хариулж болох уу гэж байгаа болохоор би микрофоныг өгч танд хариулах боломжийг олгоё.

Та өөрийнхөө үзэмжийн хүрээнд тэр асуудал нээлттэй бол тэрийгээ хариулаад явж болно.

Түүнээс таны хувийн өөрийн дотоод асуудал руу бид энд орж асуух ёсгүй.

Н.Отгончимэг: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амар амгаланг айлтгая.

Би Шүүхийн ерөнхий зөвлөлийн Улсын Их Хурлаас томилогдсон шүүгч бус гишүүн байгаа юм.

2021 оны 11 сард Улсын Их Хурлаас нээлттэй сонгон шалгаруулалтаар томилогдсон гишүүн.

Хуульд зааснаар 4 жилийн бүрэн эрхтэй байж байгаа.

Тэгэхээр үндсэндээ нэг жилийн хугацааны өмнө би энэ албан үүргээсээ чөлөөлөгдөх хүсэлтээ өгч байна гэсэн үг юм.

Д.Ганбат гишүүний асуултад нээлттэй хариулах боломжтой байна. Учир нь миний хуулийн салбарт ажиллаж байсан энэ мэдээлэл бол угаасаа би энэ албан тушаалд томилогдохдоо нээлттэй сонгон шалгаруулалтаар орсон учраас нээлттэй байгаа.

Би үндсэндээ 26, 27 жил яг энэ хуулийн салбарт ажилласан.

Энэ утгаараа Монголын үндэсний эрх зүйн тогтолцооны хөгжилд бас тодорхой хэмжээгээр санаа зовж явдаг.

Бид томилогдсоноос хойш үндсэндээ 3 жил ажилласан. Одоо энэ шүүгч бус болон шүүгч гишүүд.

Энэ хугацаанд үндсэндээ хоёр чиг үүрэг хэрэгжүүлэхээр Үндсэн хуульд заасны дагуу ажиллалаа.

Хамгийн түрүүнд мэдээж хэрэг шүүгчийн хараат бус байдлаа бид хангах үүрэгтэй. Шүүхийн ерөнхий зөвлөл.

Түүнээс гадна энэ шүүхийнхээ тогтолцооны бие даасан байдлыг хангах үүрэгтэй байгаа.

Хоёр дахь чиг үүрэг нь, мэдээж хэрэг хамгийн сайн хуульчийг л шилж сонгоод сонгон шалгаруулалт хийгээд ингээд шүүгчид нэр дэвшүүлэх ийм үндсэн үүрэгтэй байж байгаа.

Бидний ажилласан хугацаанд энэ 3 жилийн хугацаанд нэг онцлог байсан. Юу гэхээр Их Хурлаас баталсан 2021 оны Шүүхийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн энэ үетэй давхацсан байгаа.

Тэгээд энэ хугацаанд Шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор үндсэндээ эхний нэг жил яг энэ эрх зүйн орчныг яаж бэхжүүлэх вэ гэдэг дээр илүү төвлөрч ажилласан.

Дараагийн хоёр, гурав дахь жилдээ энэ шүүхийн үйлчилгээ чанарыг сайжруулахын тулд бид эдийн засгийн хувьд бэхжүүлэх асуудлыг бас Их Хуралтай ойлголцож ажилласан байгаа.

Түүнээс гадна шүүхийн үйлчилгээний чанарыг сайжруулахад нэг

чухал үзүүлэлт нь цахимжилт гэж үзээд, үндсэндээ гурав дахь жилд түлхүү цахимжилтад анхаарч ажилласан.

Ингээд ирэх жилээс бид захиргааны болов уу гэдэг ийм төсөөлөл байгаа. Хэргийн шүүх дээр цаасан хавтаст хэрэг байхгүй болгох байдлаар энэ бүх бэлтгэл ажлууд хийгдээд явж байгаа.

Эрүү иргэнийх нь энэ хэргийг бас цаасан хавтаст хэрэггүй болгох энэ технологийн болон дэд бүтцийн ажлууд ингээд хийгдээд явж байгаа гэж хэлэх байна.

Тэр хувийн байдлын хувьд ямар нэгэн дарамт шахалтад орсон ч юм уу, тийм байдлаас хүсэлтээ өгч байгаа биш гэдгийг ойлгоосой гэж хүсэж байна.

Тодорхой хэмжээгээр энэ 26 жилийн хугацаанд би академик эрдэм шинжилгээ судалгааны ажилд нэлээн цаг хугацаагаа зарцуулсан.

Улсын Их Хуралд Тамгад нь ажиллах бас ийм санал тавьсан учир яг энэ судалгаа, шинжилгээний чиглэлээр.

Миний докторын судалгааны ажил бол үндэсний эрх зүйн тогтолцооны хөгжлийн асуудал байдаг.

Энэ талаар бас Улсын Их Хурлын даргын зөвлөхөөр ажиллах санал тавьсан учир ингэж ажиллая гэж бодож хүсэлтээ.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Тодруулъя.

Д.Ганбат: Энд тэндхийн дарга нарын зөвлөх чинь билээ. Улс төрийн албан тушаал билүү, ямар албан тушаал билээ? Нэгдүгээрт. Тэр яах вэ.

Та ярьж байх юман дотроо нэг бас нэг юм дурдчихлаа. Миний хувьд аль болохоор шүүх Үндсэн хуульд нийцэж ажиллаасай, болж л өгвөл шүүхийн нэр хүнд, шүүгч нарын тэр хараат бус байдал нэг сөөм ч гэсэн ойртоосой. Шүүхийн талаарх энэ хүмүүсийн боддог бодол нөгөө социализмын үеийнх шиг битгий байгаасай. Одоо энэ ардчилал, энэ Үндсэн хуульт улс оронд нийцсэн ийм бодол руугаа хурдан түргэн ороосой гэсэн ийм байдлын үүднээс ярьдаг, хэлдэг л хүн л дээ.

Тэр Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байхад чинь одоо тэгээд дарамт хэр байв аа?

Ер нь дарамт шахалт байна уу? Энэ шүүгч нар дээр янз бүрийн дарамт шахалт ирдэг үү? Тэр талаар та их судлаач хүн шиг байна.

Тэгээд энэ талаар судалгаа энэ тэр байгаа танд?

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон.

Н.Отгончимэг: Ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байхад, тодорхой чиг үүргийг хэрэгжүүлж байхад ийм төрлийн шийдвэр гаргаач гэх байдлаар аль нэгэн иргэнээс, байгууллагаас юм уу миний хувьд ямар нэгэн дарамт шахалт ирж байгаагүй.

Мөн янз бүрийн байдлаар нөлөөлөх гэсэн оролдлогууд ирж байгаагүй.

Харин Монгол Улсын Их Хурлын 2021 онд баталсан Шүүхийн тухай хуулиар бид шүүгчийн хараат бус байдлыг хангах үүрэгтэй байгаа.

Энэ хуулиар цоо шинэ механизм оруулж өгсөн. Бид үүнийг товчлоод 73 дугаар зүйл гэж хэлдэг.

73 дугаар зүйлд ер нь төрийн өндөр албан тушаалтан, Ерөнхий сайдаас эхлүүлээд, Ерөнхийлөгчөөс эхлүүлээд Улсын Их Хурлын гишүүн, бусад иргэдийн хувьд аливаа шүүгчид нөлөөлөх орлого ийм зүйл байх юм бол Шүүхийн ерөнхий зөвлөлийн авч хэлэлцэх ийм бүрэн.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофоныг өгье. Гүйцээж хариулъя.

Н.Отгончимэг: Энэ шүүгчид нөлөөлөх гэсэн орлогыг бид авч хэлэлцсэн нэлээн хэдэн тохиолдлууд байдаг.

Энэ нь Шүүхийн тухай хуулийн 73-ын хэрэгжилтийг хангах хүрээнд энэ яг бид бүрэн эрхээ хэрэгжүүлээд явсан ийм л ажлууд байгаа.

Д.Цогтбаатар: Г.Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Ерөнхийдөө асуулт явж байгаа учраас хувь хүнийх нь сонголтыг хүндэтгэж байна.

Энэ дээр нэмж асуух асуулт бол чиг үүргийн хүрээнд дахиад томилогдсон хугацаа нэг жил үлдсэн байгаа юм байна.

Тэгэхээр энэ нэг жилийн хугацаанд өөр ажил руу шилжиж ажиллахад одоо энэ өөрийн хийе гэсэн зорилтот ажлын хүрээнд гэх юм уу, хувь хүний өөрийн зорилгын хүрээнд илүү байдлыг үүсгэж байгаа тийм нөхцөл байдал байгаа юм болов уу?

Яагаад яг энэ сонголтыг хийх болсон юм бол гэдэг дээр бас хэрвээ хариулах боломжтой бол хариулъя.

Тэгэхдээ хэрвээ хариулах боломжгүй бол бас хувь хүний нууц гэдгээр хариулахгүй байж болно. Тийм.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофоныг өгье.

Саяын энэ асуултын цаад агуулга бол ер нь энэ юун дээр ирэхэд танд өмнө нь хийж байсан ажилтай чинь холбогдуулаад тодорхой эрх зүйн хязгаарлалт байгаа юу? Тэр дээр ашиг сонирхлын зөрчил гарах уу гэсэн санаа энэ асуулт дотор явж байна гэж би ойлгож байна. Зөв үү?

Г.Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Энэ нь яах вэ, яг шууд тэр утгаараа ч биш л дээ.

Нэгэнтээ хувь хүн өөрөө цаашдынхаа карьерыг гэдэг юм уу, цаашдынхаа сонголтыг хийгээд явах эрх нь байгаа.

Тэгэхээр энэ тал дээр энэ ажлын байраа сольсноороо илүү юунд хүрэхийг хүсэж байгаа вэ? Эсвэл юуг зорьж байгаа вэ? Энэ тал дээр бас. Тийм.

Д.Цогтбаатар: Асуулт ойлгомжтой байгаа байх. Тийм ээ. 5 дугаар микрофон өгье.

Н.Отгончимэг: Г.Уянгахишиг гишүүний асуултад би яах вэ товчхон хариулж болж байна. Нээлттэй байна.

Яагаад гэвэл үндсэндээ энэ 3 жилийн хугацаанд ажиллаж байх

хугацаандаа шүүх эрх мэдлийн дараагийн 10 жилийн хөгжлийн бодлогыг Шүүхийн ерөнхий зөвлөл боловсруулах үүрэгтэй байж байгаа. Хуулиараа.

Энэ ажлын хэсгийг би ахалж ажилласан. 2024-2034 он хүртэл шүүх эрх мэдэл ямар зүгт чиглэж ажиллах юм бэ. Энэ талаар хөгжлийн ямар цаашдаа эрх зүйн орчин бий болох юм бэ гэдэг талаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын хэсэг байгуулаад, миний бие ахлаад энэ төслийг боловсруулж Улсын Их Хуралд уламжлаад ингээд хаврын чуулганаар батлуулсан.

Өөрөөр хэлбэл шүүх эрх мэдлийн цаашдын 10 жилийн хөгжлийн бодлого тодорхой болсон гэж үзэж байгаа.

Энэ дараагийн ажилд томилогдох саналыг би хуульчийн хувьд хүлээж авсан.

Тэгээд энэ шалтгаанаар бас хүлээж авсан.

Одоо шүүх эрх мэдлийн салбар дахь дараагийн 10 жилийн хөгжлийн бодлого чиглэл тодорхой болчихлоо.

Би одоо нээлттэй л ярьж байна. Энэ шилжиж ажиллах гэж байгаа ажил маань Улсын Их Хурлын даргын хууль зүйн асуудлаарх зөвлөхийн ажлыг хийх гэж байгаа.

Энэ дээр миний бас энэ судалгааны ажлын явцад өөрт тогтсон хэд хэдэн бодол байдаг юм.

Юу гэхээр хамгийн түрүүнд бид Хууль тогтоомжийн хуулиа 2015 онд батлаад ер нь нэлээн хэдэн жил болчихлоо. Үүнийг ер нь шинэчлэн

баруулах шаардлага байдаг. Энэний үндэслэлүүд ч өөрөө байдаг.

Түүнээс гадна Улсын Их Хурлаас гарч байгаа бүтээгдэхүүн болсон энэ хууль тогтоомж байдаг. Түүнээс гадна бусад захиргааны гүйцэтгэх байгууллагаас гарч байгаа энэ бүтээгдэхүүн, хэм хэмжээний акт, захиргааны акт хоёрын хоорондын харьцаа өнөөдөр алдагдсан байж байгаа. Э

Энэ дээр яах вэ, янз бүрийн тоонууд бас ярьдаг.

Тэгэхээр ингээд аваад үзэх юм бол өнөөдөр Үндсэн хуулиар Улсын Их Хурал хууль тогтоох дээд байгууллага, төрийн эрх барих дээд байгууллага байж байгаа.

Онцгой бүрэн эрхэд нь хууль тогтоох ажиллагаа байж байгаа.

Тэгтэл хуулиар энэ бүрэн эрхээ шилжүүлээд захиргааны хэм хэмжээний акт гаргах энэ бүрэн эрхийг хэт их олгочихсон ийм асуудал өөрөө эрх мэдлийн баланс тэнцвэрт би нөлөөлж байна гэж үздэг.

Тэгэхээр үүнийг хууль тогтоомжийн хуулиар засаж залруулах боломж байгаа, ийм шаардлага байгаа гэж би ойлгож байгаа.

Тэгэхээр энэ асуудлаар цаашдаа бас өөрийн хувь нэмрээ оруулаад явах боломжтой юм болов уу гэж би харж ийм сонголтыг хийсэн юм.

Д.Цогтбаатар: Хариулт хангалттай юу?

П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе.

Өнөөдрийн энэ өргөдөл хувь хүний эрхийн асуудал мэт боловч цаана нь эргээд Үндсэн хуулийн зарчим, тогтолцооны асуудал бас хөндөгдөөд байгаа юм.

Аль нэг байгууллагад өргөдөл өгөөд дараагийн хүнээ бэлтгэх, сонгох, тэр хүртэл бас ер нь боломжийг олгодог. Нэг өдөр өргөдөл өгөөд л дараагийн албан тушаал руу явдаг.

Үүний чинь цаана нөгөө Үндсэн хууль дээр шүүгч болон шүүгч бус гишүүдийн баланс 5, 5 байх энэ зарчимтай, голч шийдвэр гаргах энэ нөхцөл байдлууд үндсэндээ зүгээр яах вэ, бодит байдал дээр хэрэгжихгүй байх нөхцөлүүд бүрдэж байна л даа.

Тэгээд дээрээс нь дараагийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулалтын ажил нэлээн хугацааны хувьд асуудалтай байгаа. Бид сонгож амжих уу, үгүй юу?

Тэгэхээр мэдээж хувь хүний сонголтын асуудал байгаа боловч ер нь энэ бүрэн эрхийн хугацааг нэгэнт Улсын Их Хурлын томилолттой энэ ажлыг уг нь дуусгаад явах нь хуульчийнхаа хувьд ч тэр, хувь хүний талаасаа ч тэр энэ институцийн болон зарчмын талаасаа ч уг нь зөв байсан юм болов уу гэж би зүгээр хувьдаа бодож байгаа юм.

Тэгээд одоо нөгөө Үндсэн хуулийн 2019 оны өөрчлөлт буюу 2021 онд энэ Шүүхийн тухай хуулийг баталсан энэ хуулийн хэрэгжилт үндсэндээ гурав дахь жилээсээ алдагдах ийм нөхцөл байдал руу ингээд оруулж байна л даа.

Тэгэхээр үүнийг би хувь хүний асуудал гэж хүлээж авч чадахгүй байна.

Ер нь үүнийг энэ ажил, албан тушаалыг хашиж байгаа хүмүүс бодолцох л ёстой. Энэ цаана нь эргээд Үндсэн хуулийн зарчмыг алдагдуулах гэж байгаа асуудал шүү.

Энэ дээр томилогдсон бол хариуцлагатай, бүрэн эрхийн хугацаагаа. Үнэхээр эрүүл мэндийн шалтгаан биш л бол дуусгах ёстой шүү дээ.

Би үүнийг л хэлмээр байгаа юм.

Одоо ингээд 9 гишүүн үлдэнэ. 5 шүүгч, 4 шүүгч бус.

Би зүгээр мэдээж энэ чинь төрийн ажил, алба хийж байгаа хүмүүс зарчмаараа явах байх.

Тэгэхдээ л энэ өөрөө энэ шүүгч гишүүдийн давамгайл байдал цаашдаа давамгайлаад явах нь. Бүх шийдвэрүүд дээр.

Ийм нөхцөл байдлуудаар явахад шүүхийн энэ хараат бус, бие даасан байдал, шүүхэд иргэдийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх энэ чиглэлийн юмнууд бас улам л хардалтад орно. Энэ хариуцлагатай албан тушаал. Ийм өнцгөөс байх юм.

Тэгээд бид хэд ч гэсэн цаашдаа бодох юм гарч ирж байна. Магадгүй ийм нөхцөл байдлууд гарвал бид дараагийн сонгон шалгаруулалтаар хүний нөөцийг бүрдүүлэх асуудал байх уу. Сонгон шалгаруулалтад оролцсон хүмүүсийн тэнцсэн, ярилцлагад орсон, нээлттэй сонсголоор орсон хүмүүсийг ганц хоёр

жилдээ бас нөөц бүрдүүлж байлгах уу, үгүй юу.

Ийм тохиолдлууд гарвал. Энэ өөрөө цаад талд нь шүүхийн томилгооны асуудлууд ч гэсэн энэ дээр нөлөөтэй. Ингээд баланс алдагдаад ирнэ.

Д.Цогтбаатар: Үг хэллээ гэж ойлголоо.

О.Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Баярлалаа. Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе.

Хүсэлт өгсөн хүнээс одоо ингээд хүсэлтээ өгөөд дараагийн албан тушаал яригдаж байгаа учраас өөрөө нээлттэй бас ярьж байх шиг байна.

Тэгэхдээ энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр орсон Үндсэн хуулийн бүтцийн энэ байгууллага болсон Шүүхийн ерөнхий зөвлөлийн бол маш том зорилго тавьж байгуулагдсан.

Шүүхийн хараат бус байдал, шүүгчдийн хараат бус байдал, бие даасан байдал. Тийм ээ.

Дээр нь шүүгчийг сонгон шалгаруулах, сайн шүүгчийг сонгон шалгаруулах ийм чухал үүрэг.

Тэгэхээр манай шударга ёсыг тогтоох хамгийн эцсийн шийдвэр гаргах энэ шүүх байгууллага маань хэр сайн байх вэ. Үнэхээр яг шударга ёсондоо ойр.

Та томилогдсоноосоо хойш 3 жил энэ тал дээр судалгаа хийж ажилласан байна.

Тэгэхээр иргэдийн зүгээс ирж байгаа санал, хүсэлтүүд дотор, ялангуяа иргэний хэргийн шүүх, аж ахуйн нэгжүүд энэ шүүхэд итгэх итгэл тийм ч өндөр биш байна.

Нөгөө аж ахуйн болон санхүүгийн асуудлуудаа шүүгч нар маань сайн ойлгохгүй байна. Шүүгчдийн чанар тиймхэн байна. Бас нөлөөлөлд орж байна гээд олон асуудлууд тавьдаг.

Тэгэхээр би яах вэ, таныг бас 3 жил ажилласан болохоор. Нэгэнт бас хүсэлтээ өгсөн хүний хувьд ер нь таныг энэ 3 жил Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байхад шүүхийн хараат бус байдал, бие даасан байдал, шүүгчдийн хараат бус байдал дээр ямар ахиц дэвшил гарсан гэж Та үзэж байна?

Энэ дээр илүү бэхжүүлэхийн тулд хийх ёстой. Гол гогцоо нь гэж үзэж байна?

Хоёрдугаарт, сайн шүүгчийг бэлтгэх сонгон шалгаруулалт дээр бид цаашид юун дээр анхаарах ёстой гэж үзэж байна? Та яах вэ, дахиад Улсын Их Хурал дээр ирж ажиллах ийм төлөвлөгөөтэй байгаа юм байна. Хууль тогтоох.

Энэ дээр ч гэсэн энэ бас хамаарах байх. Гэхдээ таны хувьд яг энэ 3 жил ажиллаад ямар ахиц дэвшил гарч байна. Өөр ахиц дэвшлийг хурдасгахын тулд юуг бид сайжруулах, хамгийн гол гогцоонууд нь байна гэж харж байна гэдгийг л асуумаар байна.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон өгье.

Н.Отгончимэг: О.Номинчимэг гишүүний асуултад хариулъя.

Хараат бус байдал дээр ямар ахиц гарсан бэ гэхээр би энэ дээр үнэхээрийн том ахиц гарсан гэж хэлнэ.

Энэ нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн явуулж байгаа үйл ажиллагаатай холбоотой гэхээсээ илүү 2021 оны Шүүхийн тухай хуулиар бий болсон одоо тэр механизм өөрөө маш зөв механизм байсан. 73 дугаар зүйл дээр байдаг энэ механизм байдаг.

Энэ механизмыг нэлээн хэд хэдэн удаа Шүүхийн ерөнхий зөвлөл хэрэгжүүлсэн.

Ингээд хэрэгжүүлээд эхлэхэд бид тодорхой хэмжээгээр төрийн өндөр албан тушаалтны үг, үйлдлийг ч авч хэлэлцэж байсан тохиолдол бий. Үүний зэрэгцээ тодорхой нийгмийн зүтгэлтэн, эсвэл сошиал орчинд идэвхтэй нөлөө үзүүлэгч хүмүүсийг ч авч ирээд хэлэлцэж байсан тохиолдол бий.

Мөн тодорхой хэвлэл, мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагаа явуулж байдаг мэргэжлийн хүмүүсийг авч хэлэлцэж байсан тохиолдлууд бий.

Тэр тохиолдол бүрийн дараа үр дүн бий болж байсан.

Тухайн тодорхой нөлөөлсөн шинж бүхий үйлдлүүдээ зогсоож байсан ийм тохиолдлууд бий.

Тэгээд ингээд аваад үзэхэд энэ механизмын нөлөөгөөр шүүгчид нөлөөлөх энэ зүйл нэлээн хумигдсан гэж би харж байгаа.

Сонгон шалгаруулалттай холбоотой сайжруулах вэ гэдэг дээр.

Манай нэлээн олон гишүүд энэ дээр бас санал нэг байдаг.

Сонгон шалгаруулалт бол үндсэндээ хоёр хэсэг байхаар хуульд заасан байдаг. Бичгийн шалгалт болон ярилцлагын буюу тэр хүний зан төлөв, ёс зүйг шалгах хэсэг гэж хоёр хуваагддаг юм.

Бичгийн шалгалт бол харьцангуй ер нь нэлээн удаан хугацаанд практик нь тогтчихсон ийм байдаг. Үүнийг яах вэ боломжийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа гээд ойлгоно.

Гагцхүү тухайн нэр дэвшигчийн ёс зүй, темперамент, зан характер, нийгэмд биеэ авч явж байгаа байдлыг бид таньж мэдэхэд арга зүй дутаж байна.

Энэ эрх зүйн орчин сайжрах ёстой юм байна гэж үзэж байгаа.

Энэ дээр илүүтэй өөр мэргэжлийн шинжээч нарыг оролцуулаад үүнийг сайжруулах ёстой юм билээ.

Энэ дээр бид гаднын зөвлөхүүдийг аваад ажиллаж байгаа ийм асуудлууд байгаа юм.

Иргэдийн итгэлийг яаж дээшлүүлэх вэ гэж.

Шүүхийн ерөнхий зөвлөл иргэдийн итгэлийг дээшлүүлэх асуудал дээр шүүн таслах ажиллагаанд оролцох ямар ч эрх байдаггүй.

Энэ зорилгоор нэг боломж бий гэж би хардаг. Энэ бол шүүхийн үйлчилгээний чанарт хамгийн голлох нөлөө үзүүлдэг энэ нэг фактор байдаг. Энэ бол хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааг богино хугацаанд хэрэгжүүлэх энэ асуудал байж байгаа.

Хэрвээ тухайн хэрэг маргааныг шүүх дээр шийдэж байгаа тохиолдолд сунжруулалгүйгээр, хойшлуулалгүйгээр, аль болох богино хугацаанд шийдэх юм бол тодорхой хэмжээгээр иргэдийн итгэлд нөлөө үзүүлдэг гэж ярьдаг.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн энэ дээр яаж оролцоо хангах боломжтой юм бэ гэхээр бид тодорхой хуулийн ахицуудыг хоёр удаа байдлаар хийсэн байгаа.

Төсвийн хууль дээр хавсралт байдаг. Энэ дээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд тодорхой хэмжээгээр улсаас мөнгө аваад энэ зарцуулж байгаагийн хувьд үр дүнг хүлээлгэж өгөх ёстой байдаг.

Энэ үр дүнг нь төсвийн хуульд гэж заасан байдаг вэ гэхээр нийт хэргийнхээ тодорхой хувийг яг хугацаанд нь шийднэ шүү гэдэг үр дүнг хавсралтаар оруулсан байдаг.

Өмнө нь биднийг ирэхээс өмнөх хуулиуд дээр 91 хувийн үзүүлэлт байсан. Өөрөөр хэлбэл нийт шийдэж байгаа эрүү, иргэний хэргийн 91 хувийг нь бид яг энэ мөнгө аваад санхүүжээд явж байгаа нийтийн энэ төрийн байгууллагын хувьд 91 хувийг нь хугацаандаа шийднэ шүү гээд амлалт аваад үр дүн гаргах ёстой байсан.

Гэвч бид статистик үзэхэд энэ биелшгүй.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон өгье. Гүйцээгээд хариулья. 5 дугаар микрофон. 1 минут. Гүйцээгээд.

Н.Отгончимэг: 91 хувь бол хэзээ ч Монгол Улсын түүхэнд байгаагүй ийм хувь байсан.

Жишээлж хэлэхэд, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ярих юм бол нийт хэргийн 50 гаруй хувь нь л хугацаандаа шийдэгддэг ийм дундаж статистик үзүүлэлттэй.

Хамгийн гайгүй нь гэхэд эрүүгийн хэргийг хугацаандаа шийдэж байгаа үзүүлэлт 80 гаруй хувьтай байсан.

Иргэний хэргийн хувьд нь 70 гаруй хувьтай ийм байж байгаа.

Бид үүнийг Сангийн яамтай ярьж байгаад энэ дээр маш бодитой хандах юм бол өнөөдөр бид энэ үзүүлэлтийг буулгах ёстой юм байна. Буулгаж байгаад он оноор өөрөө ахицаа бодитой тооцох ёстой юм байна гээд.

2024 оны төсвийн тухай хуульд энэ хувь 79 гэдэг ийм хувьд байж байгаа. Өөрөөр хэлбэл Шүүхийн ерөнхий зөвлөл нийт хэрэг маргааны 79 хувийг нь хугацаанд нь шийднэ шүү гэдэг ийм үр дүн гаргах ёстой байж байгаа.

Тэгэхээр энэ чинь өөрөө эргээд цаанаа.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Тодруулах юм уу? **О.Номинчимэг** гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Баярлалаа.

Ер нь сайн шүүгчийг сонгон шалгаруулах ажлын суурь нь ерөөсөө л хүний нөөц шүү дээ. Хүний нөөцөө багаас нь яаж бэлдэх вэ, хуульчдаа бид яаж илүү сайн чанартай бэлдэх вэ.

Эндээсээ л ерөөсөө эхлэх ёстой гэж харж байгаа юм.

Тэгээд одоо манай Монгол Улсад хуульч нар бэлтгэж байгаа систем өөрөө байгаа байдал маань хангалттай гэвэл бас хангалттай биш.

Дээр нь ер нь гадаад улсад хамгийн сайнууд нь л шүүгч болдог шүү дээ.

Тэгтэл яг бодит байдал дээрээ одоо хамгийн онц сурдаг сайнууд нь хувийн өмгөөллийн фирм ч байдаг юм уу, гаднын ийм байгууллага гээд л явчихдаг.

Тэгээд энэ шигшигдсээр шигшигдсээр гэдэг шиг ямар хүмүүс хуульч болох ингээд үүд хаалга механизм байна гэдэг дээр бас анхаармаар юм шиг байгаа юм.

Тэгээд яах вэ, бид хүний нөөцөө аягүй сайжруулахын тулд мэдээж сонгон шалгаруулалт дээрээ тийм ч тест, ийм ч тест гээд л яаж болно. Гэхдээ бас яах вэ яг гол гогцоо бол энэ хууль зүйн боловсролын асуудал дээр бас таныг анхаар.../минут дуусав/

Д.Цогтбаатар: С.Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Таны хувийн байр суурийг хүндэтгэж байна.

Тэгэхдээ хэдэн зүйл байгаа юм. Парламентын гишүүд чинь өөрсдөө тангараг өргөчихсөн хүмүүс учраас танаас яагаад ийм асуултууд асуугаад байна гэхээр та хугацаанаасаа өмнө хүсэлт өгч байгаатай холбогдуулж л асуулт асуугаад байна гэдгийг та бас

нөгөө хүндээр хүлээж авахгүй эрүүлээр хүлээж аваасай гэж бодож байна. Нэг.

Хоёрдугаарт та бол жирийн субъект биш. Улсын Их Хурлаас тэнд очиж томилогдсон субъект байгаа.

Тэгэхээр легитим буюу хууль зүйн хүчин чадалтай чадвар чинь **“de facto”**, **“de jure”** гээд хоёр юмнаас бүрдэж байгаа шүү дээ.

Тэгэхээр өнөөдөр таны асуудал **“de jure”** шийдэгдэх гэж байгаа. Энэ хэлэлцэгдэж байна. Хууль зүйн байнгын хорооны хурлаар.

Тэгэнгүүт та гэж байна гэхээр Их Хурлын зүгээс ажлын санал ирсэн, би хүлээж авсан гээд **“de facto”** шийдвэрээ гаргачхээд ороод ирсэн гэж ойлгогдохоор байгаа юм.

Тэгэхээр энэ бол нөгөө хувь хүний хэдийгээр сонголт, ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох асуудал мөн боловчиг ард талд нь нэг хүний хөдөлгөөнөөс үүдээд маш олон процедур, цаг хугацааны хүлээлтүүд бий болчихоод байгаа.

Тэгэхээр гэж хэлэх гэж байна гэхээр та магадгүй манай Их Хурлын гишүүд таныг чөлөөлөхөөс татгалзсан тохиолдолд таны цаашаа ажил чинь ингээд үргэлжлээд явна. Энэ тохиолдолд та яах вэ?

Өөрөөр хэлбэл бид нэг асуулт байдаг шүү дээ. *“Төр бидний төлөө хийх вэ гэж асуухаас илүүтэйгээр би энэ нийгмийн төлөө хийх вэ”* гэж асуух гээд Ж.Ф.Кеннедигийн алдартай асуулт байдаг.

Тэгэхээр тухайн хүн хэчнээн супер гайхамшигтай байхаас үл шалтгаалж тухайн нийгмийнхээ системдээ бид гэмтэл учруулахгүйгээр ажил үүргээ гүйцэтгэх ёстой байгаад байдаг. Нэг ийм зарчмын асуудал байна.

Тэгэхээр асуулт нь болохоор манай Хууль зүйн байнгын хороо таны хүсэлтийг хүлээж авахгүй үргэлжлүүлэн ажиллуулахаар болсон тохиолдолд танд итгэл үнэмшлийн хувьд яах вэ? Та “de facto” шийдвэр хувьдаа гаргачихсан ч гэсэн “de jure” бид ингээд энд шийдвэр гаргачих юм бол яах вэ? Та энэ асуултад товчхон хариулж өгөхгүй юу?

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон өгье.

Н.Отгончимэг: Баярлалаа. С.Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя.

Юуны өмнө тэр О.Номинчимэг гишүүний хуульчдын боловсрол бол яг тийм байгаа. Үнэхээр асуудалтай болчихсон.

Сонгон шалгаруулалтад шилдэг хуульч нар ирэхээ байсан. Тэр бол үнэн.

Энэ асуудлыг шийдэх тэр гарц гаргалгааг “Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого” дээр хийгээд өгчихсөн байж байгаа. Хэн ямар ажлыг хариуцах вэ.

Ер нь хуульчдын боловсролын асуудал, эрх зүйн орчныг нь хөгжүүлэх ёстой гэдэг асуудал бас тусчихсан байгаа.

Үүнийг дараагийн Их Хурал маань үүнийг хийх байх гэж найдаж байна.

С.Эрдэнэболд гишүүний асуулт. Би бас их таатай хариулмаар байна л даа. Таны асуултад.

Ер нь хэрвээ Хууль зүйн байнгын хороо, чуулганаас чөлөөлөхгүй гэдэг шийдвэр гаргавал ингэх боломж бас байгаа. Тийм. Чөлөөлөхгүй гэдэг шийдвэр гаргавал би Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний албан үүргээ үргэлжлүүлээд гүйцэтгээд явна.

Энэ дээр ямар нэгэн буцах, санаа бодол урвах зүйл байхгүй. Үүний ердөө ганцхан л шалтгаан байгаа.

Бид эрх зүйчид, хуульчид бол үндэсний эрх зүйн тогтолцоо аль ч утгаараа хөгжөөсэй гэж сэтгэл зүрхээ, ажил хөдөлмөрөө зориулж явдаг.

Тэгэхээр энэ ажил хөдөлмөр өөрөө тэр шүүхийн системдээ байх, хууль тогтоох энэ системд орж ирж явахад адилхан л тэр зүрх цохилж, хөдөлмөр өөрөө буцалж байх ёстой байгаа юм.

Тэгэхээр энэ дээр ялгаагүй үргэлжлүүлээд л явах боломжтой.

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Одоогоос яг 3 жилийн өмнө шүүхийн хууль батлагдаж Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо гэсэн Үндсэн хуулийн байгууллагуудыг бид анх удаа нээлттэй, ардчилсан зарчмаар, сонгон шалгаруулалтаар оруулж, нийтийн сонголд оруулж, тэгээд томилж байсан.

Энэ нэр дэвшүүлэх асуудлыг урьд нь аль нэг дарга дэвшүүлдэг байсан бол өөрөө нэр дэвшээд, би өөрөө өөрийгөө

итгэл үнэмшлээрээ нэр дэвшүүлж байна гээд ингэж өрсөлддөг болгосон.

Энэ шалгуураар би чадна, би энэ шүүхийн хараат бус байдлын төлөө Шүүхийн ерөнхий зөвлөлд ажиллана гээд Та нэр дэвшээд томилогдож байсан.

Тэгэхээр энэ таны асуудал биш байгаад байгаа юм. Одоо бол. Яагаад гэхээр Монгол Улсын хууль тогтоох төрийн эрх барих дээд байгууллагаас Та шүүхийн хараат бус байдлыг хангана гээд 4 жилийн баталгаатайгаар томилогдсон Үндсэн хуулийн байгууллагын гишүүн болчиход байгаа байхгүй юу. Үндсэн хуулийн байгууллага.

Үндсэн хуулийн байгууллага гэх утгаараа таны дээр ямар ч дарга байхгүй. Бид ч дарга нар биш. Их Хурал. Ерөнхийлөгч ч биш, Их Хурлын гишүүд ч биш, Засгийн газар ч биш.

Та хэнээс ч хараат бус ажиллана гээд тангараг өргөчихсөн.

Тэгээд ийм логикийн асуудал гарчхаад байхгүй юу.

Нөгөө хэнээс ч хараат бус ажиллана. Би одоо улс төрөөс ч хараат бус ажиллана гээд тангараг өргөчихсөн, Их Хурлаас томилогдчихсон хүн. Би одоо Их Хурлын даргын зөвлөх болохоор ярьчихсан юм гээд ороод ирэхээр чинь энэ чинь асуудал үүсээд байна шүү дээ.

Танд ямар ч дарга байхгүй байгаа байхгүй юу. Таны дээр ард түмэн гэдэг ганцхан дарга байна.

Тэгэнгүүт нэг хүний, нэг даргад үйлчилдэг албан тушаалаар энэ ард түмний мандатыг сольё гээд би шийдчихсэн юмаа гээд байхаар чинь

наадах чинь уншигдахгүй байна л даа. Тэгээд тохирчихсон юмаа гээд байна шүү дээ. Та чинь.

Тэгж ярих юм бол Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлын гишүүдтэй уулзах ч ёсгүй байгаа шүү. Хуулиараа тийм байгаа шүү.

Та энд ингээд уулзаад тохирчихсон. Би ажил, албан тушаалын асуудал ярьчихсан гэж яриад сууж байна шүү. Энэ дээр хариулт авъя.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон өгье.

Н.Отгончимэг: Б.Энхбаяр гишүүний асуултад хариулъя.

Миний үгийг гуйвуулахгүй байгаач ээ гэж хүсэж байна. Б.Энхбаяр гишүүнээс.

Тохирчихсон асуудал байхгүй. Томилогдохын тулд процесс байдаг. Санал тавьсан гэж би хэлсэн.

Би энэ саналыг өөрийнхөө хэмжээнд шийдлээ гаргасан учир өнөөдөр би хүсэлтээ өгч байгаа юм шүү.

Түрүүн С.Эрдэнэболд гишүүн хэлж байсан. Энэ дефактаа үзэгдэл байж байгаа.

Тэгэхээр энэ дээр тохиролцоод шийддэг зүйл биш л дээ. Энд цаана нь ашиг сонирхлын хууль байгаа. Түүнийгээ давж байна уу, үгүй юу гээд олон процедур байж байгаа. Энэ бол тохиролцоод шийддэг асуудал биш ээ.

4 жилийн хугацаатай томилогдсон гэж байна.

Яг үнэндээ гишүүд ээ, бид байна шүү дээ пар хийтэл 4 жилийн дараа бүгд ингээд бүрэн эрх нь дуусна. Одоо энэ 10 гишүүний. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн.

Энэ бол бодлогын залгамж халаа энд байхгүй болно.

Ер нь энэ хуульд олон механизм байдаг шүү дээ. Зарим бүрэлдэхүүнд нь байгаа гишүүдийнх нь бүрэн эрхийг арай богино хугацаатай хийдэг. Ингэж ротац хийж сөөлжүүлдэг.

Үнэндээ ирэх оны 11 сард энэ 10 гишүүн бол бүгд бүрэн эрхийн хугацаа дуусахад энэ байгууллагын бодлогын залгамж халаа өөрөө бас эргэлзээтэй байдалд хүрнэ.

Гэхдээ бид бас үүнийг даван туулахын тулд аль болох ажлын албаа чадавхжуулаад ингээд явдаг. Гэсэн ч гэсэн энд асуудал байдаг. Бүх зүйлд эерэг сөрөг хоёр тал байдаг гэж би өөрөө ойлгож явдаг.

Тэгэхээр бас зүгээр эерэг талыг нь ярих юм бол тодорхой хэмжээгээр Та бүхэн чөлөөлөх шийдвэр гаргалаа гэхэд энэ дараагийн хүн орж ирэхэд бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байна.

Тэгэхээр энэ дээр тодорхой хэмжээний хувьд, хугацааны хувьд ротац явагдана.

Тэгэхээр энэ залгамж чанар бас Шүүхийн ерөнхий зөвлөлийн өөрийнх нь бодлогын залгамж чанар ингэж уламжлагдаж үлдэх бас нэг ийм тал байгаа гэж би харж байна.

Миний хувьд үнэхээрийн том шийдвэр гаргасан. Яг өөрийнхөө хувьд ярих юм бол.

Би одоо энэ 26 жил хуулийн байгууллагад ч юм уу, энэ салбарт ажиллахдаа улс төрийн алба хашиж байгаагүй. Энэ улс төрийн алба байж байгаа.

Хэрвээ процесс цаашаа явах юм бол улс төрийн албанд анх удаа би томилогдож байгаа ийм байдал болно.

Энэ бол амаргүй байсан. Би мэргэжлээрээ ажиллаж явсан. Хамгийн дээд тал нь би төрийн захиргааны албан тушаал хашиж явж байсан.

Тэгэхээр энэ бол тийм амаргүй шийдвэр байсан гэдгийг би хэлэхийг хүсэж байна.

Тэгээд яагаад би үүнийг их нээлттэй ярьж байгаа юм бэ гэхээр үүнийг тохирчихсон, энэ тэр асуудал гэхээсээ илүү энэ бүх нөхцөлийг шийдвэр гаргах.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа.

Н.Отгончимэг гишүүн 3 жилийн өмнө нээлттэй сонгон шалгаруулалтаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд олон хүмүүс хүсэлтээ өгч, сонгон шалгаруулалтад оролцож, ингээд сонгон шалгаруулалтаар нэгээр гарч ирж эндээ Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн болсон.

Гэтэл нөгөө гарам дээр морио сольдоггүйтэй адилхан бүрэн эрхийн

хугацаа 4 жил гээд сонгогдож томилогдож ажиллана гээд тангараг өргөчхөөд өнөөдөр хугацаанаасаа өмнө өргөдлөө өгөөд явах гэж байгаа нь өөрөө энэ хуулийн зөрчил мөн үү? Нэгд.

Хоёрт, ёс зүйн асуудал мөн үү?

Та өөрөө хуульч хүн. Үндсэн хуулийн байгууллагын Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр 3 орчим жил ажиллалаа.

Шүүгч нарын сонгон шалгаруулалтын асуудлыг хариуцаж байсан байгууллагад ажиллаж байсан хүн.

Гэтэл одоо ингээд хугацаандаа ажиллахгүй хугацаанаасаа өмнө ингээд өргөдлөө өгөөд явж байгаа нь энэ хуулийг чинь ер нь яг хэн хэрэгжүүлэх ёстой юм бэ? Монгол Улсын хуулиудыг.

Шүүхийн тухай хуулийг зөрчиж байгаа асуудал мөн үү? Хуульч нар, шүүгч нар хуулийг сахиулах үүрэгтэй юу? Мөрдөж ажиллах үүрэгтэй юу?

Тэгээд 4 жил ажиллана, би чадна гээд бөөн цаг зав гаргаад, бөөн сонгон шалгаруулалт болоод, 3, 4 сар болоод ингээд сонгон шалгаруулалтаас гарч ирж байсан хүн өнөөдөр хугацаанаасаа өмнө би өөр ажил, албан тушаалд шилжих боллоо гээд гараад явж байгаа нь өөрөө хэр ёс зүйн асуудал вэ? Ёс зүйд хэр нийцэж байгаа асуудал вэ?

Хууль сахиулагчийн хувьд, хуулийг хэрэгжүүлдэг хүмүүсийн хувьд, хуулийг хэрэгжүүлэхийг санал болгодог, хянаж байдаг байсан, шүүгч нарынхаа асуудлыг хянадаг байсан улсууд одоо ингээд өнөөдөр өөрсдөө асуудлыг гаргаад явж байгаа нь хэр зохимжтой вэ?

Та өөрөө өнгөрсөн жил “Шүүхийн эрх мэдлийн шинэчлэлийн бодлого”-ын баримт бичгийг боловсруулж, түүн дээр ажиллахад гол рольтой ажилласан хүн.

Ингээд Их Хурал энэ бодлогын баримт бичгийг чинь баталж өгсөн.

Тэгээд одоо ингээд бодлогын баримт бичгээ хэрэгжүүлээд ажил дээр цаашдаа үр дүнг нь гаргаад явах байтал харин ч энэ салбараа орхиод ингээд явж байгаа нь хэр нийцтэй юм бол. Нийцтэй юм бол. Энэ дээр та хариулт өгөөч.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон.

Н.Отгончимэг: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр миний хүсэлт гаргасан процесс хуулийн дагуу явж байгаа гэж би ойлгож байгаа. Энэ дээр 2021 оны шүүхийн тухай хуульд заасан үндэслэл байгаа. Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж болох.

Тэгэхээр би үүнийг гишүүд маань бас их нээлттэй энд хандаач ээ гэж бас хүсэх байна.

Би 3 жилийн өмнө Та бүхний томилолтоор энэ иргэдийн төлөөлөл болж шүүхийн системд ажиллахаар томилогдсон хүн байж байгаа, хуульч хүн байж байгаа.

Тэр утгаараа би хэдийгээр Та бүхэнд тайлагнах үүрэггүй, бүрэн бие дааж, хараат бусаар үйл ажиллагаа явуулах ийм эрх үүрэгтэй хүн байгаа ч гэсэн би нэгэн төрлийн Улсын Их Хурлын хүний нөөцийн боловсон хүчин

гэж би ойлгож байна. Яг энэ томилгоогоо.

Тэр үед сонгон шалгаруулалтад шалгарч, Та бүхэн намайг энэ шүүхийн системд ажиллаарай гээд томилсон байж байгаа. Тэр утгаараа хуулийн салбар дахь боловсон хүчнийг шүүхийн системд томилж ажиллуулсан гэж бодож байгаа.

Тэгээд энэ 3 жилд нэлээдгүй ажил хийсэн. Хамгийн том ажил бол шүүх эрх мэдлийн 10 жилийн хөгжлийн бодлогыг батлуулсан.

Би санаж байна. Тэр үед ажлын хэсгийг тухайн үеийн Хууль зүйн байнгын хорооны дарга ахалж байсан.

Тэр ажлын хэсэг дээр орж ярилцлагад орохдоо л хамгийн түрүүнд чухал ажил бол энэ 10 жилийн хөгжлийн бодлого байх юм гэж би хэлж байснаа санаж байна.

Тэгэхээр энэ чухал ажлаа би хийж гүйцэтгэсэн гэж ойлгож байна.

Ёс зүйн асуудал мөн үү, үгүй юу гээд. Энэ бол ийм л учиртай юм даа.

Ер нь хуульч хүн бол энэ хуулийн салбарын яг мэргэжлээрээ хаана ч ажилласан байсан өөрөө нийгэмдээ, үндэсний эрх зүйн тогтолцоондоо контрибюшн хийгээд хувь нэмэр оруулаад би явж байдаг гэж боддог.

Тэгэхээр энэ бол ёс зүйн асуудал гэхээсээ илүү тухайн хүний өөрөө хөдөлмөрийг хаана илүү зохион байгуулалтын хувьд оновчтой байрлуулах вэ л гэдэг асуудал байгаа юм гэж би ойлгож байгаа.

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье. Тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа.

Ёс зүйн асуудал мөн үү гэж асуусантай холбогдуулаад яагаад ийм санал ирж байхад хуульч хүний хувьд хүлээж авах боломжгүй юм гээд гарах тийм ёс зүйн гэдэг юм уу, хувь хүний байр суурь байж болоогүй юм уу?

Би одоо ингээд 4 жилийн томилгоотой юм. Их Хурлаас томилогдсон юм. Сонгон шалгаруулалтаар томилсон юм. Олон арван хүмүүстэй өрсөлдөж, олон арван хүмүүсийг өрсөлдөөнөөс гаргаж, ингэж урдуур нь орж ирсэн.

Хэрвээ та өрсөлдөөгүй байсан бол таны оронд ахиад нэг өөр хүн, хоёроор бичигдсэн хүн ороод сууж байх ёстой шүү дээ. Бүрэн эрхийнхээ хугацаанд ажиллаад.

Энэ дээр би ёс зүйн асуудал мөн үү гэдгийг асуугаад байгаа нь энэ.

Боломжгүй гэж хариулах бололцоо байсан уу?

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон өгье.

Н.Отгончимэг: Тэгэхээр би боломжгүй гэж, боломжтой гэж хариулахаасаа өмнө би ер нь энэ үндэсний эрх зүйн тогтолцооны хөгжилд хаана нь байвал, аль цаг хугацаанд байвал миний хувь нэмэр оролцоо илүү гарч ирэх юм бэ гэдэг дээр л би жин дарж үзсэн.

Тэгээд энэ 3 жилийн хугацаанд. Би түрүүн хэлсэн. Үнэхээр чамгүй чухал

ажлууд хийгдсэн. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дээр.

Үүнтэй холбогдуулаад хаврын чуулганаар нэлээн том зарчмын өөрчлөлтүүд орсон байгаа. Үүнийг дараа дараагийн Шүүхийн ерөнхий зөвлөл хангаад явах ёстой байгаа.

Би өөрийнхөө хувьд, хуульч хүний хувьд өөрийнхөө туршлага, энэ олон жилийн судалгаа хийсэн энэ үр дүн, үр бүтээлдээ би хаана, аль цаг хугацаанд илүү байвал, хаана байвал илүү үр өгөөж нь гарах вэ гэдэг дээр л.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Асуулт асууж дууслаа.

Одоо үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Б.Заяабал гишүүнээр тасаллаа. Д.Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Тухайн үед 3 жилийн өмнө бас таныг сонгон шалгаруулалтад оролцоод сонгон шалгаруулж байсан хүний нэг л дээ би.

Ер нь их л шаардлага хангасан ийм хүн орж иржээ. Бид зөв сонгон шалгаруулж бай гэсэн ийм бодолтой байсан.

Та ч гэсэн хариулж байхад сая манай Хууль зүйн байнгын хорооныхон анхаармаар бас хэд хэдэн зүйл ярьж байна.

Тухайлбал, пар гээд л нөгөө арвуулаа байхгүй болчихдог. Тийм ээ. Шүүхийн ерөнхий зөвлөл. Тэр нь ротацийн журмаар явбал зүйтэй гэдэг. Тийм ээ. Энэ дээр бид бас анхаарах нь зүйтэй байх гэж бодож байна.

Тэр туршлагатай, чадвартай хүмүүс нь солигдоод явж байх нь зөв өө. Бас авууштай ийм хэд хэдэн саналуудыг ярьж байна гэж ойлгож байна.

Нөгөө талаар бас ийм байна. Ер нь одоо энэ сонгон шалгаруулалт Шүүхийн ерөнхий зөвлөл хараат бус ажиллах ёстой. Маш чухал байгууллага.

Бид маш эвгүй байдалд орж байна л даа. Улсын Их Хурал маань сонгон шалгаруулалтаар явсан 5 хүний 1 маань ингээд нэг их хүндэтгэн үзэх шалтгаан гэж бодохгүй л байна л даа. Таны наад бодлыг.

Тухайн үед хэн нэгэн улс төрийн хамааралтай, ямар нэгэн даргын оролцоогүй ийм 5 хүнээ шалгарууллаа гэж би бодож явж байсан. Энэ маань одоо бас тэгээд энэ олон түмний харж байгаа асуулт хариулт, энэ яриагаар бас эргэлзээ төрүүлэхээр л болчхоод байгаа юм л даа.

Нэг нүүдлийн шувууд шиг, улирлын үед ингээд нутаг усаа солиод явдаг шиг дарга нар дагаад томилгоо хийлгүүлээд явдаг нэг хэсэг байна.

Манайх чинь авлигын индексээр маш их хойшоо байгаа шүү дээ. Урагшаа явж чадахгүй л яваад байна.

Тэр багаа бүрдүүлж ажилладаг энэ тэр бол нэг сайн тал байдаг байх. Тэр хурдан түргэн ажиллах энээ тэрээ гээд. Бас муу тал байна.

Ямар муу тал байна вэ гэхээр тэр багаараа очоод хуучин ажил төрлөө зүгээр хэвийн хийж байсан хүмүүсийг дарамтлах, шахах ийм байдлууд элбэг болчихсон. Түүн дээр бид тэгээд л нэг байж л байдаг байдал шиг ийм болчхоод байна.

Би танд юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр албан тушаал дэвшиж байгаа хувь хүнийхээ хувьд, улс төрийнхөө сонголтыг хийж байгаа энэ тэр бол таны хувийн асуудал байх л даа. Өвчин зовлонтой юм уу, хувийн хэвшилд очих гэж байгаа юм уу, ийм бол хүндэтгэн үзэх шалтгаан гэж би ойлгоод байгаа.

Тэгээд хүн хүний өөрийнх нь бодол өөр л дөө.

Тэгээд би таныг ахиж нэг бодож үзээч ээ. Бид ямар ч байсан сонгон шалгаруулаад явуулсан Улсын Их Хурал нь юм, Хууль зүйн байнгын хороо нь юм.

Тэгээд ийм нэг. Ахиад наад шийдвэртээ ч юм уу, өөрийнхөө барьж байгаа байр суурин дээрээ ахиад нэг бодоод үзээч ээ гэсэн ийм санал хэлэх гээд байна л даа.

Тэгээд нөгөө шүүгчид маань дотроосоо гаргаад ирсэн 5 хүн бол хэвийн ажил төрлөө хийгээд яваад байдаг. Манайхаас томилсон 5 хүний 4 нь ямар ч байсан бүрэн эрхийнхээ 4 жилийн хугацааг дуусгая гээд л. Хэрэв өвчин зовлон нь тохиолдчихгүй, янз бүрийн шалтаг шалтгаан, дарамт байхгүй бол ингээд л дуусгах гээд л яваад байгаа юм байна.

Таныг энэ бүрэн эрхээ дуусгачхаасай гэсэн ийм л сонгон шалгаруулаад явсан хүний хувьд бодоод байна.

Тэгэхгүй бол одоо бас нэг улс төр лүү явж байгаа ч юм шиг, бүрэн эрхээ дуусгаагүй. Тэр дарга нарыг дагаж явдаг бас нүүдлийн шувууд шиг ийм ойлголт өгч болохгүй л дээ.

Тэгээд манай дарга нар чинь билээ. Энэ Ардын намын дарга нар чинь бүр социализмын үед манай нэг удирдагчийн хэлж байсан тэр “ард түмний эрх ашиг нэгдүгээрт” гээд байгаа шүү дээ. Хувь хүний эрх ашиг гуравдугаарт гээд.

Би бол арай өөр бодолтой л байдаг л даа. Одоо бол. Тийм. Тэгээд иймэрхүү юм хэлчихье.

Д.Цогтбаатар: Г.Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Сая ерөнхийдөө Байнгын хорооны гишүүдийн асуулт болон хүсэлт гаргасан Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийхээ тайлбаруудыг сонслоо.

Тэгэхээр зарчмын хувьд ер нь яах вэ, нэгэнтээ өөрөө хэлчихсэн учраас Их Хурлын даргын зөвлөх гэдэг бол өөрөө яг улс төрийн албан тушаалтан.

Тэр талаасаа бид дээр ч гэсэн яг Хууль зүйн байнгын хороо өнөөдөрхөн бичигдээд байж байсан. Тийм ээ. Их Хурлын даргаас нэлээн олон ажлын хэсгийг байгуулж байгаа. Хууль тогтоомж хууль эрх зүйн орчныг шинэ цагийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төгөлдөржүүлэх гээд.

Тэгэхээр энэ дээр нэлээн олон хуулийн төслүүд яригдана. Нэлээн олон хуулиудын нийцлийг хангах.

Түрүүний хүсэлт гаргасан Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний маань хэлсэнчлэн яг тэр журмуудыг цэгцлэх гэх мэтийн ажлууд хийгдэх гэж байгаа. Нэлээн том ажлууд төлөвлөгдөж хийгдэж байгаа.

Тэгэхээр энэ дээр яг хувь хүнийх нь хувьд, зөвлөхийн хувьд, Хууль зүйн бодлогын зөвлөхийн хувьд жишээлбэл оруулах хувь нэмэр нь өөрөө хэр байх вэ гэдэг дээр өөрийнхөө шийдвэрийг гаргахад жин дарж үзсэн гэж байна л даа.

Тэгэхээр тэр талаас нь би тухайн хүний сонголтод хүндэтгэлтэй хандаж байна.

Нөгөө талаасаа 4 жил томилогдсон. 3 жилдээ ер нь хийсэн ажлуудыг сонсоход нэлээн ажлууд хийчихсэн. Тийм ээ.

Цаашдаа энэ нэг жилийн хугацаагаа илүү үр бүтээлтэй гэх юм уу, хувь хүнийх нь хувьд гэсэн үг шүү дээ. Тийм ээ.

Үндэсний эрх зүйн тогтолцооных нь хувьд илүү оролцоотой байна гэдэг ийм шийдлийг гаргасан хувь хүнийх нь шийдвэрийг хүндэтгэж үзэж байна.

Тэгээд яах вэ, Байнгын хорооноос гишүүд маань шийдвэрээ гаргаад явах байх. Ер нь бол хувь хүний зүгээс тэгж л хэлмээр байна даа.

Д.Цогтбаатар: Б.Заяабал гишүүний микрофоныг өгье.

Б.Заяабал: Баярлалаа.

Тэгэхээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний алба гэдэг бол зүгээр нэг төрийн албатай бас харьцуулахгүй ийм алба. Төрийн өндөр албан тушаалтан. Манай зарим гишүүд сая бас ярьж байна.

Тэгэхээр төрийн өндөр албан тушаалтан өөр ажил руу шилжих гэж байгаа юм гэдэг ийм байдлаар хүсэлт

гаргах нь миний хувьд ёс зүйн зөрчил байна л гэж харагдаж байна.

Ер нь бид Хууль зүйн байнгын хорооны хүрээнд төрийн албанд иргэдийг сонгон шалгаруулж томилох дээрээ бид аягүй их, Төрийн албаны хууль нь ч тэр, аягүй их процесстой, аягүй их анхаарал хандуулдаг мөртөө төрийн албанаас гарч байгаа үйл ажиллагаан дээр ерөөсөө анхаарал маш сул байгаа.

Ялангуяа өргөдлөө өгөөд гарч байгаа хүмүүсийг, ялангуяа энэ дунд шатад ажиллаж байгаа энэ төрийн албан тушаалтнуудын хувьд өргөдлөө өгөөд гарч байгаа дээр бид их онцгой анхаарал хандуулах ёстой гэж бодож явдаг гэдгийг энд бас илэрхийлж хэлье.

Ингээд миний хувьд таныг дэмжих боломжгүй байгаа саналаа хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж, үгээ хэлж дуусаж байна.

Би өөрийнхөө зүгээс хэдэн зүйл хэлье гэж бодож байна.

Гишүүд ээ. Энд нэг ийм асуудал гарчихлаа шүү. Энэ хэлэлцүүлгээс. Одоо энэ хүн чинь ажлаа өгье гээд өргөдлөө өгчихсөн байна шүү дээ.

Ер нь ажлаа өгье, би өөр ажил хийнэ гээд өргөдлөө өгөх эрх бол хүний ёстой үндсэн эрх шүү дээ.

Одоо та хэд маань нэг юм бодоорой. Бид ажлаа үргэлжлүүлж хий гэдэг хандлага гаргана гэдэг юу болчхож байна гэхээр дургүй хүнээр ийм чухал ажлыг хийлгэх гээд байгаа болж хувирч байна. Энэ хүн чинь өргөдөл өгснөөрөө

тэр байр сууриа илэрхийлчхээд байгаа байхгүй юу. Нэг ийм асуудал.

Хоёрдугаарт, өөрөөр хэлбэл тэр өргөдөл өгч байгаа дээр бол ямар ч асуудал байхгүй. Энэ хүний эрхийн асуудал.

Бид үргэлжлүүлээд ажиллуулах гэхээр өөрөө хүсэхгүй байгаа хүнийг хүчээр ажиллуулж байгаа юм шиг. Монголын төр хэнийг ч гуйж ажиллуулахгүй шүү дээ.

Цалингаа аваад хийж байгаа ийм өндөр албан тушаалтныг та дургүй ч гэсэн ажиллаад өгөөч гэж царай алдаж гуйх тухай асуудал бас байхгүй.

Одоо энд чинь яг энэ асуудал бүр яг шууд тавигдаж байгаа болчихоод байна. Та нар маань бодоорой. Энэ буцах. Тэр дараагийн томилогдох асуудал бол өнөөдөр бид нарын хэлэлцэж байгаа асуудал биш.

Өнөөдөр бид нарын хэлэлцэж байгаа асуудал энэ хүн ажлаа өгье гэчихсэн байгаад л байгаад байна шүү дээ.

Тэгэхээр би контекстоос тэр дараагийн асуудлыг бол үнэхээр бид нарын хэлэлцэх асуудал биш. Төрийн ийм чухал ажлыг буцах хүнээр ачаа бүү татуул гэж монгол үг байдаг.

Тэгээд энэ өнцгөөс нь бас нэг авч үзэх ёстой байх. Зарим хүмүүс маань эмзэглээд байх шиг байна. Ингээд өргөдлөө өгч байна гээд.

Энэ чинь амьдрал юм чинь ингээд л нэг томилчихоод л хаашаа ч хөдлөхгүй байна гэж бид хэрэв бодож байгаа бол

зөндөө шалтгаанаар энэ ажлаа өгөх нөхцөлүүд бүрдэж гарна.

Тэгээд бид нарын хүслээс үл харгалзаад хүмүүс ажлаа өгөх, ажил солигдох ийм нөхцөлүүд. Өвдчихвөл одоо жишээлбэл яах вэ. Та ажилдаа үлд гээд кноп дараад сууж байх уу.

Би өөрөөр хэлбэл энэ хүний тухай асуудал яриагүй байна шүү. Энэ институцийн тогтвортой байдлын тухай асуудал.

Тэгээд түрүүн сая яригдсан нэг юм бол 10 хүн зэрэг ажлаа өгөхөд бол энэ бол жинхэнээсээ асуудал гарч ирэх юм байна.

Үүнийг Байнгын хороо бид бодож үзэхгүй бол энэ Их Хурлын хэлэлцэх асуудал.

Түрүүн Н.Отгончимэг гуай нэг юм хэлж байна лээ. Улсын Их Хуралд би тайлагнах үүрэггүй ч гэсэн гээд. Бид таныг тайлагнах үүрэггүй асуудлаар чинь ирж дуудаж бид хэлэлцээгүй шүү дээ.

Та өргөдлөө өгсөн. Томилогдох болон ажлаа өгөх асуудал чинь бид нарын эрх. Бид ярих асуудлаа ярьдаг газраа яриад сууж байгаа.

Түүнээс таныг өөр юм хийчихлээ гээд дуудаж авчраад яагаад ийм шийдвэр гаргав гэж яриагүй. Таны ажлаа өгөх асуудал энэ Байнгын хороон дээр хэлэлцэгдэх ёстой асуудал.

Тэгэхээр үүнийгээ бас та анхаарч ярьж байна биз цаашдаа.

Ингээд миний хэлэх гэсэн зүйл энэ. Гишүүд ээ, томьёолол чинь.

Тэгэхээр Наранчулууны Отгончимэг гишүүнийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээс чөлөөлөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/ Би бол дэмжинэ.

41.7 хувийн санал авч энэ санал дэмжигдсэнгүй.

Ямар ч гэсэн ингээд Байнгын хорооны энэ саналаа бид цааш уламжлаад

явах болно. Энэ шийдвэр ингээд гарч байна.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд танилцуулна.

Нэг асуудал маань хэлэлцэгдээд явлаа.

Хоёрдугаар асуудал руугаа орёе.

**Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл,
Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон
“Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг,
санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуул хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг уг нь танилцуулах ёстой байгаа.

Гэхдээ энэ дээр хэдэн хуудас байгаа болохоор би шууд юугаар нь танилцуулаад явчихъя. Байгууллагуудаар нь. Бас тал талдаа нэг нэгнийхээ цагийг хүндэтгэх үүднээс.

Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Хүний эрхийн Үндэсний Комисс, Үндэсний аудитын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, Хил хамгаалах ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар гэсэн байгууллагууд байна.

Гадаадын иргэн, харьяатын газар, Архивын ерөнхий газар, Оюуны өмчийн газар гэсэн ийм газрууд байна.

Гэхдээ хуралдааны протоколд энэ хуралдаанд ирсэн албан тушаалтнуудын нэрс бүгд тэмдэглэгдээд орно.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдоод ирсэн албан тушаалтнуудыг болон байгууллагуудыг танилцууллаа. /алх цохив/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улс Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх илтгэлийг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан сайдын микрофоныг өгье. 4 дүгээр микрофон байна.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн, Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 27-ны өдөр нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэг танилцуулсан.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2023 онд 23.3 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр дүнгийн цэвэр зээлийн дүн 22.5 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2.2 их наяд төгрөгийн алдагдалтай төлөвлөгдсөнөөс 785.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан гарсан ба сүүлийн жилүүдэд төсвийн алдагдлыг үе шаттайгаар буурууллаа.

Монгол улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, Авлигатай тэмцэх газар, Улсын дээд шүүх, Улсын Ерөнхий прокурор, Хүний эрхийн Үндэсний Комисс, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комисс, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, нийт 288 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 1 их наяд 161.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, урсгал зардалд 1 их наяд 87.0 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 73.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Улсын төсвөөс 1 их наяд 129.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бол төсөвт байгууллагын өөрийн орлогоор 21.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2023 онд төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж, Төсвийн тухай хуулийн дагуу “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Б.Жавхлан сайд танилцуулж дууслаа.

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Монгол Улсын Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тус тус хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна.

Д.Загджав даргын микрофоныг өгье. 3 дугаар микрофон.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд 229 тайлан нэгтгэснээс 140 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 89 байгууллагыг түүврээс хамруулсан ба 134 байгууллагад өөрчлөлтгүй, 6 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитад нийт 18.3 тэрбум төгрөгийн 352 зөрчил илэрснээс 0.1 тэрбум төгрөгийн 29 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7.1 тэрбум төгрөгийн 98 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 11.1 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 225 зөвлөмж өгсөн байна.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 64.5 тэрбум төгрөгийн 186 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитор шалгасан Нийслэлийн аудитор 47.9 тэрбум төгрөгийн 77 зөрчил илэрснээс 2.2 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, 25 албан шаардлага хүргүүлж, 45.7 тэрбум төгрөгийн зөрчилд 52 зөвлөмж өгсөн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 106.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 60.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 25 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төсөл, арга хэмжээний санхүүжилт 97 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Санхүүгийн нэгдсэн тайлан нэгтгэсэн 2 байгууллагын аудит байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 139.3 сая төгрөгийн 7 зөрчил илэрснээс 3.9 сая төгрөгийн 2 зөрчилд

төлбөрийн акт тогтоож, 135.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 64.3 сая төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан Нийслэлийн аудитаар илэрсэн 314.2 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг өгсөн.

3.Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн үүсэл хийсэн аудитаар хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

Санхүүгийн нэгдсэн тайланд 43 тайлан нэгтгэснээс 31 байгууллагын санхүүгийн тайлан дүгнэлт гаргаж, 12 байгууллагыг түүвэрт хамруулж, харьяа 31 байгууллагад өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитор нийт 3.7 тэрбум төгрөгийн 57 зөрчил илэрснээс 33.8 сая төгрөгийн зөрчил, 6 төлбөрийн акт тогтоож, 3.4 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 16 албан шаардлага хүргүүлж, 188.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 34 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан Нийслэлийн асуудлаар 440.2 сая төгрөгийн 15 зөрчил илэрснээс 2 албан шаардлага хүргүүлж, 440.2 сая төгрөгийн зөрчилд 13 зөвлөмж өгсөн.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 387.3 сая төгрөгийн 26 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

4.Шүүхийн сахилгын хорооны даргын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 40.4 сая төгрөгийн 2 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан Нийслэлийн асуудлаар 150.6 сая төгрөгийн илэрсэн 3 зөрчил илэрснээс 72.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, 1 албан шаардлага, 78.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зүйл энд өгсөн.

5.Улсын ерөнхий прокурорын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитор өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд 44 тайлан нэгтгэгдсэнээс 28 байгууллагын санхүүгийн тайлан дүгнэлт гаргаж, 18 байгууллагыг түүвэрт хамруулж, харьяа 26 байгууллагад өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитэд нийт 342.6 сая төгрөгийн 42 зөрчил илэрснээс 1.2 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 199.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 9 албан шаардлага хүргүүлж, 141.7 сая төгрөгийн зөрчилд 31 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн явцад шалгасан нийслэлийн аудитаар 76.1 сая төгрөгийн 7 зөрчил илэрснээс 1 албан шаардлага хүргүүлж, 76.1 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 685.4 сая

төгрөгийн 28 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Улсын төр төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 27.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 13.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төсөл, арга хэмжээний санхүүжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

6.Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хязгаарлалттай дүгнэлт өгч, нийт 124.7 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс 80.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлж, 44.2 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 302.4 сая төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитад шалгасан Нийслэлийн аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

7.Авлигатай тэмцэх газрын даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 2 тайлан хийгдсэнээс аудитаас ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 7.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргах байх 1 зөвлөмж өглөө.

8.Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын даргын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд хязгаартай дүгнэлт өгсөн бөгөөд санхүүгийн тайлангийн аудитаар нийт 178.5 сая

төгрөгийн зөрчил илэрснээс 76.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 албан шаардлага хүргүүлж, 102 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Нягтлан бодох бүртгэл, тайлантай холбоотой 22.7 сая төгрөгийн бүртгэл тайлагналын 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитад шалгасан нийслэлийн аудитаар 3.6 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 1 албан шаардлага хүргүүлжээ.

Тус Байнгын хорооны харьяа төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлтэд үндэслэн цаашид анхаарах дараах асуудлууд байгаа юм.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд харьяалах төр, хувийн хэвшлийн хамтын оролцоотой "Төрийн Үнэт Цаас Хэвлэл" төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компаниас худалдан авсан гадаад паспортын бэлдцээс 1.4 тэрбум төгрөгийн үнэ бүхий 20 мянга 116 ширхэг алдаатай бэлдцийн үлдэгдлийг "Төрийн Үнэт Цаас Хэвлэл" төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани, Улсын бүртгэлийн ерөнхий газар аль нь хариуцах нь тодорхойгүй.

Тус компанийн дүрэмд төрийн эзэмшлийн хөрөнгийг 15.1 тэрбум төгрөг, хувийн эзэмшлийн хөрөнгийг 15.5 тэрбум төгрөг, нийт 31.6 тэрбум төгрөг байхаар заасан боловч "Мигасон" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 23 тэрбум төгрөгийн хөрөнгийг ашиглан үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа нь хувь

эзэмшлийн маргаан үүсэх эрсдэлийг бий болгосныг анхаарах.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын харьяа 13 байгууллага эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад байгууллага, иргэдээс байршуулсан 3 тэрбум төгрөгийн барьцааны өр төлбөрийг санхүүгийн тайлан, данс бүртгэлд тайлагнаагүй алдааг залруулах.

Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулаагүй гэрээг дүгнэсэн актгүй шууд гэрээ байгуулсан зөрчлийг давтан гаргахгүй байх.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгж худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, аудитор тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах.

Танилцуулж дууслаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Ингээд нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Ц.Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Г.Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Сайн байцгаана уу? Энэ өдрийн мэндийг хүргэе.

Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний төсвийн

ерөнхийлөн захирагчтай холбоотой тоонуудаас асуулт асуумаар байна.

Нэгдүгээрт, яах вэ, ер нь гүйцэтгэлийнх нь хувиар шүүж үзэхээр 100 хувиасаа хэтэрсэн гэдэг юм уу, хэтрүүлэн зарцуулсан нэг л мөр байгаад байгаа байхгүй юу. Тэр нь нөгөө “урамшуулал хэсэг” дээр байгаа. Цалин хөлс болон нэмэгдэл “урамшуулал” гэж байгаа юм.

Тэгэхээр жишээлэх юм бол Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн 2023 оны төсвийн зарлагын гүйцэтгэл дээр “урамшуулал” дээр жишээлбэл 229 хувийн гүйцэтгэл, илүү зарцуулалттай буюу 454 сая.

Үнийн дүнгээр нь хэлэх юм бол Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2023 оны төсвийн зарлагын гүйцэтгэл гэнгүүт 1.8 тэрбумын урамшууллын зардал илүү буюу зөрүүтэй байна.

Улсын ерөнхий прокурорын 2023 оны төсвийн зарлагын гүйцэтгэл дээр 3 тэрбумын бас илүү зарцуулалттай байна. Бас “урамшуулал хэсэг” дээр.

Хууль зүйн яаман дээр мөн хэтрэлттэй буюу 4.3 тэрбумын хэтэрсэн зардал “урамшуулал хэсэг” дээр байгаад байна.

Тэгэхээр нэгдүгээр асуулт нь энэ “урамшуулал” хэтрээд байдгийн шалтгаан нь юм бол? Яг төсөвлөсөн мөнгөнөөс хэтрээд байгаа учир шалтгаан нь яг юундаа байдаг юм бол гэдгийг нь бас тодруулж асуумаар байна.

Хоёрдугаар асуулт нь, яг энэ зарлагын төсвийнхөө угаасаа хамгийн том хэсэг нь энэ бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ гэж байгаа.

Тэгэхээр энэ дээр бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж дээр жишээлбэл Авлигатай тэмцэх газар 13 тэрбум ч гэдэг юм уу. Тийм ээ.

Тэгэхээр энэ дээр сая Үндэсний Аудитын газраас бас дүгнэлт дээр болон санамж, зөвлөмж дээр дурдагдаад, хэлэгдээд өнгөрлөө. Бусадтай байгуулах гэрээ контрактаа журмын дагуу байгуулсан уу, шууд байгуулах болон тендерээр явах зөрчил илэрсэн үү гэдэг тал дээр бас дурдаад өнгөрлөө гэж ойлголоо.

Тэгэхээр энэ дээр задаргаа бас асууж үзмээр байна. Өөрөөр хэлэх юм бол энэ бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж дээр хэдэн хувь нь яг тендерийнхээ хуулиар явдаг юм? Хэдэн хувь нь шууд гэрээ байгуулахаар явдаг юм бэ гэдэг. Үүнийг бас тодруулж асуумаар байна.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Шүүхийн ерөнхий зөвлөл хариулт бэлдэх ёстой байх. Өөр хэд хэдэн байгууллагууд байлаа. Хууль зүйн яам. Яг энэ Хууль зүйн яам, Шүүхийн ерөнхий зөвлөлийн байсан. Прокурор.

Хууль зүйн яамнаас хэн байна? Төрийн нарийн бичгийн дарга нь. Микрофонд ойртож суухгүй бол. Солигдоод суучих уу? 1 дүгээр микрофонтой солигдоод суучих.

Тэгээд дараа нь Шүүхийн ерөнхий зөвлөл бэлдэж байгаарай. 6 дугаар Микрофон дээр солигдоод суучих. Шүүхийн ерөнхий зөвлөл. Тэгээд прокурор. 5 дугаар микрофон дээр

солигдоод суучих. Тэгээд шууд шууд хариулаад явчих.

Н.Мягмар: Г.Уянгахишиг гишүүний асуултад хариулья.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар.

Тайлангаар илэрхийлэгдэж байгаа дүнгээр урамшууллын зардал дээр 4 гаруй тэрбумын хэтрэлт харагдаж байгаа нь ерөнхий бүлгээрээ хэтрэлт байхгүй учраас энэ зөрчилгүй дүгнэлттэй харагдаж байгаа.

Гэхдээ таны гол асуудлын агуулга талаас нь танилцуулах юм бол энэ хууль тогтоомж болон Засгийн газрын журмуудаар төрийн албан хаагчдын урамшууллын хэмжээ нь нэмэгдсэнтэй холбоотойгоор батлагдсан төсөвтөө багтаан нэмэгдүүлэх ийм байдлаар зохицуулалт хийж, нөгөө төсвийн ерөнхийлөн захирагч дотроо зохицуулалт хийх замаар ингэж нэмэгдсэн юмнууд байж байгаа.

Өөрөөр хэлэх юм бол хууль тогтоомжийн дагуу урамшуулалыг олгох ёстой хугацаатай зүйл дээр нь үүнийг нь олгоод явж байгаа юм.

Тийм учраас энэ маань аудитын дүгнэлтээр ерөнхий бүлгээрээ зөрчилгүй ангилалдаа орж явж байгаа.

Д.Цогтбаатар: Шүүхийн ерөнхий зөвлөл. 6 дугаар микрофон дээр очоод суучих. 1 дээр суучих. Шүүхийн ерөнхий зөвлөл. 1 дүгээр микрофон өгье.

Байнгын хорооны дарга эрхэм гишүүдийн өдрийн мэнд хүргэе.

Б.Эрдэнэтулга: Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга байна.

Г.Уянгахишиг гишүүний асуусан асуултад Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга бас хариулчихсан байх.

Яг мөн адил хууль тогтоомжид нийцүүлж нэг сар хүртэлх цалингийн урамшууллийг олгосонтой холбоотойгоор манай дээр ийм дүн бас харагдсан байгаа. 1.8 тэрбум гэсэн асуудал.

Мөн түрүүн Ерөнхий аудитор хэлсэн байгаа. Тэр шүүгчээс таслан сэргийлэх арга хэмжээний барьцаа хөрөнгийн дүгнэлтийн талаар бас тайлбарлаж өгье.

Эрүүгийн хэрэг хянах ажиллагааны явцад эрүүгийн оролцогчдоос барьцаа дансанд байршуулсан хөрөнгийг хэрхэн яаж бүртгэх талаар бид тухайн үедээ буюу 2018 онд Сангийн яамны Төрийн бичгээс асуусан. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 7 сарын 4338 дугаар тогтоолоор санхүүгийн тайлангийнхаа тодруулга тайландаа бүртгэж байя гэсэн манайд чиглэл өгсөн байдаг.

Энэ чиглэлийн дагуу бүртгэж явсан. 2023 онд ирсэн аудитын багаас энэ тайланг бүртгэхгүй ээ. Өр төлбөр, мөнгөн хөрөнгөөр бүртгэх шаардлагатай гэснээс ингээд энэ дүгнэлтүүд гарсан байгаа.

Д.Цогтбаатар: Прокурор 6 дугаар микрофон дээр суучих. Дээд шүүх эхлээд 1 дүгээр микрофон.

С.Заяадэлгэр: Улсын дээд шүүх бол цалин урамшууллын сангаа 2023 онд нийт 634 сая төгрөгөөр хэмнэж ажилласан. Нийт дүнгээрээ.

Урамшууллын хэсэг нь нэмэгдсэн шалтгаан нь хагас жилээр шүүгчид олгох урамшууллын журам Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2023 оны хагас жилээс эхэлж батлагдан шинээр мөрдөгдсөн.

Мөн төрийн албан хаагчид “урамшуулал” олгох журам Засгийн газрын 319 дүгээр тогтоолоор мөн нэмэгдэж батлагдсантай холбоотойгоор урамшууллын ангилал дотроо бага хэмжээгээр өссөнөөс тухайн “урамшуулал хэсэг” дээрээ хэтэрсэн боловчиг нийт цалингийнхаа дүнгээрээ хэмнэгдсэн байгаа.

Д.Цогтбаатар: 6 дугаар микрофон. Манайхан нэрээ хэлээд, албан тушаалаа хэлээд явж байхгүй бол гишүүд маань шинэ шинэ гишүүд байгаа. Өөрсдийгөө танилцуулж байж асуултдаа хариулаарай.

М.Чинбат: Г.Уянгахишиг гишүүний асуултад хариулъя.

Улсын ерөнхий прокурорын орлогч М.Чинбат.

Улсын ерөнхий прокурорын газрын хувьд Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагч нартаа үр дүнгийн “урамшуулал” олгосон.

Энэ бол цалингийн сангийн бүлгийн дүнгээрээ хэтрээгүй.

Мөн нэмж 12 сард Засгийн газрын 2023 оны 12 сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрээр төрийн албан хаагч нарт нэг

сарын “урамшуулал” нэмж олгохоор шийдвэрлэсэн. Энэ дагуу цалингийн сангийн батлагдсан төсөвтөө багтаагаад урамшуулыг олгосон.

Цалингийн сан 2023 оны гүйцэтгэлээрээ хэмнэгдэж ажилласан байгаа.

Д.Цогтбаатар: Нэмж асуух уу? Г.Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Сая ерөнхийдөө ойлгочихлоо.

Тэгээд энэ дээр жишээлбэл Улсын ерөнхий прокурорын 2023 оны төсвийн зарлагын гүйцэтгэл дээр нэмэгдэл хэсэг дээр 4.7 тэрбумын хэмнэлт гарчихсан байгаа шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр энэ нэмэгдэл нь өөрөө төсөвлөсөн хөрөнгөөсөө багасдаг шалтгааныг нь микрофон дээр байгаа учраас асуучихъя.

Д.Цогтбаатар: 6 дугаар микрофон.

М.Чинбат: Тухайн жилийн ажиллагсдын маань тодорхой тооны хэсэг хүмүүс ажиллаагүй байснаас болж бас хэмнэгдсэн байх гэж бодож байна.

Нарийн учрыг нь тэгж ойлгож байна.

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Хууль зүй, дотоод хэргийн яам. Төрийн нарийн бичгийн дарга нь. Энэ хоёр дахь асуултаа хариулъя.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажилтай холбогдуулаад. Тэрний төсөв, санхүүгийн.

Г.Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Хоёр дахь асуулт ийм байсан юм. Одоо ер нь бүгдийнх нь тайланг харахаар хамгийн өндөр дүн нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж гэж байгаа байхгүй юу.

Тэгээд жишээлбэл Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны төсвийн зарлагын гүйцэтгэл дээр 59.8 тэрбум гэж байгаа юм.

Тэгэхээр энэ бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ гэдэг дотроо ер нь одоо нөгөө нэг тендерийн журмаар явсан хэдэн хувь нь байдаг юм бол? Шууд гэрээ байгуулсан хэдэн хувь нь байдаг юм бол?

Ер нь ямар төрлийн ажил, үйлчилгээнүүд байдаг юм болоо гэдэг асуулт.

Д.Цогтбаатар: Н.Мягмар дарга хариулах уу? 1 дүгээр микрофон.

Н.Мягмар: Г.Уянгахишиг гишүүний асуултад хариулъя.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

Салбарын хэмжээнд бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ гэдэг манай цагдаа, хил хамгаалах, улсын бүртгэл зэрэг байгууллагуудын маань үйлчилгээ, худалдан авалттай холбоотой ийм арга хэмжээнүүд тайлагнагддаг.

Тийм учраас манай цагдаа, хил хамгаалах, улсын бүртгэл зэрэг байгууллагууд маань тодруулж яг энэ дотор ямар арга хэмжээ, ажил батлагдаж гүйцэтгэх вэ гэдгийг тодруулж хариулах боломжтой байж байгаа.

Д.Цогтбаатар: Төрийн нарийн бичгийн даргын хариултыг би хангалттай гэж үзэж байна.

Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Яах вэ, тэгээд жил болгон л ингээд аудитын тайлан орж ирээд л жил жилдээ л баахан санхүүгийн зөрчил юм илрээд л явдаг л даа.

Аудитын байгууллага ер нь энэ санхүүгийн зөрчил гараад байгаад гарсныг нь л илрүүлдэг болохоос биш Та бүхэн ер нь санхүүгийн зөрчил гараад байгаа үндсэн суурь шалтгаан нөхцөлийг нь ер нь дүгнэж үзсэн үү?

Яг юунаас болоод ингээд санхүүгийн зөрчил гараад байна вэ? Жил болгон.

Хууль, эрх зүйгээс юм уу? Эсвэл төсвийн ерөнхийлөн захирагчдын сахилга бат, төсвийн сахилга бат алдагдаад байна уу? Хариуцлагын асуудал сул байна уу гээд ингээд үзвэл ер нь зөрчил дутагдал гараад байгаа үндэс шалтгаан суурь нөхцөлийг Та бүхэн гэж хэлэхээр байна вэ гэдгийг нэгд асууя.

Хоёрт, орон нутагт төсвийн ерөнхийлөн захирагчаар ажиллаж байсан хүний хувьд бас яг орон нутагт миний хувьд ойлгох нь төсөв, энэ санхүүгийн зөрчил дутагдал гараад байгаа нэг шалтгаан нь энэ төсвийн байгууллагуудын нягтлан, нярвуудын ур

чадварын асуудал байгаа юм. Санхүүгийн, мэдлэг боловсролын асуудал байгаа юм.

Яг үнэнийг хэлэхэд сүүлийн үед нягтлан, нярваар төгсөж байгаа сургууль төгсөж ирсэн шинэ залуу нягтлангууд яг үнэнийг хэлэхэд тайлан баланс гаргаж уншиж чадахгүй л хүүхдүүд ирж байгаа шүү дээ. Яг үнэнийг хэлэхэд.

Тэгээд болсон болоогүй байж байгаад 2, 3 жил, 4 жил, 5 жил ажиллаж байж нэг юм тайлан баланс гаргах хэмжээний л түвшинд хүрч байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ хүний нөөцийн асуудал, энэ салбарын нягтлан, нярвуудын ур чадварын асуудлыг цаашдаа ер нь яах ёстой юм бэ?

Яг үнэнийг хэлэхэд сум, орон нутаг, дүүрэг, орон нутагт нягтлангаар ажиллах боловсон хүчний хүрэлцээ хангамжийн асуудал бас дутмаг байгаа. Яг үнэнийг хэлэхэд.

Тэгээд нэг нягтлан мэргэжилтэй хүүхэд олохоор нөгөөдөх нь тайлан баланс гаргаж чаддаггүй. Үүнээс болоод наад санхүүгийн зөрчил дутагдал гараад байгаа чинь нэг их олон арван тэрбум төгрөгийн зөрчил яриад байгаа боловч дотроо яг үнэнээ хэлэхэд дийлэнх олонх нь, бараг 90 хувь нь зүгээр анхан шатны санхүүгийн баримт материал бүрдэл дутуу гэдэг юмнууд л дийлэнх олонх нь байдаг юм шүү дээ.

Түүнээс нэг их айхтар идэж уугаад гэдэг юм уу, авлигын гэдэг юм уу, ашиг сонирхлын гэдэг юм уу, хулгай зээлийн гэдэг юм нь харьцангуй гайгүй байдаг.

Дийлэнх олонх нь ерөөсөө санхүүгийн баримт материал, анхан шатын баримт материал бүрдлээс болоод л зөрчил гээд л үзчихдэг.

Тэгээд л тэр нь тоо нь нэмэгдээд л нэг л их аймаар салбарын хэмжээний том санхүүгийн зөрчил гэж харагдаад байгаа болохоос биш яг дотор нь аваад үзэхээр тэр нягтлан, нярвуудыг чинь тэр ур чадварын асуудлаас болоод ингээд байдаг.

Энэ дээр манай Сангийн яам энэ нягтлан, нярвуудын энэ хүний нөөцийн асуудал, нөгөө орон нутагт төрийн албан хаагч нар ажиллахгүй байна, олдхоггүй байна, хүний нөөц дутагдалтай байна гээд байгаа чинь яг асуудал нь санхүүгийн нягтлан, нярвуудын асуудал чинь номер нэг болчхоод байгаа юм шүү.

Д.Цогтбаатар: Сангийн Яам хариулах уу? 4 дүгээр микрофон өгье.

Б.Жавхлан: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Би 100 хувь санал нийлж байна. 100 хувь санал нийлж байна.

Ковидын үед 2021, 2022 онуудад манай татварын салбар бүр нэлээн хүнд байдалд орсон.

30 гаруй татварын байцаагч нар сумдад ажиллаж байсан хүмүүс маань, албан хаагч нар маань ажлаа орхиж явсан.

Тэгээд тэр үед зарлахад ерөөсөө огт хүн орж ирэхгүй байсан. Маш хүнд байдалд орсон.

Төсвийн байгууллагуудын нягтлангуудын хувьд ч гэсэн ялгаагүй

маш өндөр шаардлагатай. Тэгсэн мөртөө нөгөө талдаа маш өндөр хариуцлагатай.

Тэгээд манайд төсвийн байгууллагуудын нягтлангуудын нэг зовлон нь “ТЗ”^[төрийн захиргаа] биш, тэгээд “ТҮ”^[төрийн үйлчилгээ] рүү гээд “ТҮ”-тэй ажиллахын хувьд байдаг.

Сүүлийн нэг жилийн хугацаанд “мэргэжлийн ТҮ” гэж шинэ ангилал руу орж ирсэн байгаа.

Тийм учраас энд яг хүний нөөцийн төрийн боловсон хүчний бодлогын асуудал энд яг ингээд алдагдаад, зөрчилтэй асуудлууд үүсэж байгаа.

Харин сүүлийн 2 жилийн хугацаанд цалин пүнлүүн дээр бол яах вэ “ТЗ” нарын хувьд нэлээн боломжийн болсон.

Ингээд буцаад төрийн алба руугаа хүмүүс орох ийм хандлага нь эрс нэмэгдсэн байгаа.

Энэ дээр яг нягтлангууд дээр үлдчихээд байгаа юм.

Сая өнгөрсөн оноос эхлээд Төрийн албан хаагчийн тухай хуульд өөрчлөлт орсны дагуу “ТЗ”-ийн албан хаагч нар 5 жил тутмын нэмэгдлүүдийг, 6 сарынхаа нэмэгдлүүдийг авч эхэлсэн байгаа.

Ер нь “ТЗ”-ийн бүх албан хаагч нар “ТТ”-ийнхэн бүгдээрээ.

Энэ дотор яг “мэргэжлийн ТҮ” тэр дундаа маш их хариуцлагатай ажилладаг. Заавал дээд боловсрол, өөр олон шаардлагыг хангаж байж ордог энэ төсвийн байгууллагын нягтлангууд энд бас хоцорчхоод байгаа юм.

Тийм учраас Ц.Сандаг-Очир гишүүний хэлж байгаа тэр цалин пүнлүүтэй холбоотой асуудал дээр ч бид бодох асуудлууд байгаа.

Ялангуяа ирэх 2025 оны төсөв дээрээс энэ төсвийн байгууллагуудын нийгмийн асуудал, энэ цалин пүнлүү нь “ТЗ” нараас орхигдчихоод байгааг зэрэгцүүлж аваачих энэ төрийн хүний нөөцийн бодлогын асуудлуудыг бас шийдэхээр төлөвлөж байгаа. Тийм.

Үнэн шүү. Тэр нэг их олон тэрбум төгрөгийн дүн яригдаад байгаа мөртөө тэр дээр яг тэр мөнгөтэй холбоотой зөрчил гэхээсээ илүү яг анхан шатны баримтуудтай холбоотой л.

Дандаа тэр дутуу баримт бүрдүүлсэн, гарын үсэг дутуу. Дандаа тийм зөрчлүүд байгаад байдаг.

Тэгэхдээ энэ нь өөрөө маш том хариуцлагын асуудал байдаг.

Энэ дээр ажилладаг нягтлангуудынхаа бусад хувийн сектортой өрсөлдөх тэр нийгмийн асуудлууд гэдгийг нь шийдэх аягүй чухал байгаа. Тийм.

Д.Цогтбаатар: Хариултыг хангалттай гэж үзлээ.

Аудит. 3 дугаар микрофон.

Д.Загджав: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Ц.Сандаг-Очир гишүүн амьдрал дээр төсвийн ерөнхийлөн захирагчаас эхлээд ажиллаж байсан болохоор бүх зүйлийг ойлгож байгаа.

Ер нь мэдээж хууль эрх зүйн орчин бас боловсронгуй болоогүй. Хамгийн гол нь сахилга хариуцлагагүй байдал байна.

Нөгөөтээгүүр хүний нөөцийн, ялангуяа санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудын хүний нөөцийн бүрдүүлэлт, бэлтгэл, тэд нарыг давтан сургах, тэр мэргэжилтнүүдийн ур чадвар, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах гэдгийг дахин хэлэхэд энэ их дутмаг байгаа юм.

Яг энэ мэргэжил шаардсан ажил дээр бас өөр мэргэжлийн хүмүүс томилох ийм асуудлууд байгаа.

Энэ бүгд дээр бид бас Их Хурлын тухайн Байнгын хороонд яг энэ аудитын дүгнэлтийнхээ төгсгөлд бид зөвлөмж өгөөд байгаа.

Сая би тэр зөвлөмж дээр дурдсан.

Дээрх гишүүний асуусан зарим худалдан авалт шууд гэрээгээр явсан зүйлүүд байгаа гэж.

Тиймэрхүү зүйлүүд байгаа. Тэр нь мэдээж гүйцэтгэх ажлын шугамаар. Энэ чиглэлд нь бид бас аудит хийж явдаг юм.

Хариулт дууслаа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Тодруулах уу? Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Би гүйцэтгэлтэй холбоогүйгээр.

Манай Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд энд байгаа байгууллагуудын албан хаагчдын

орон нутгийн нэмэгдэл ерөөсөө хийгдэж чадахгүй байгаа.

Өнгөрсөн жил орон нутгийн нэмэгдлийг орон нутагт 20 хувь нэмэгдүүлснээр маш олон төрийн албан хаагч нар ажлын байран дээрээ тогтвортой ажиллах тэр сэдлийг төрүүлсэн шүү. Энэ Засгийн газар, Сангийн яам сайн арга хэмжээ авсан.

“ТЗ”, “ТҮ” нар. Олон багш нар ажлаасаа гарах гэж байсан, олон эмч нар ажлаасаа гарах гэж байсан.

Тэгээд орон нутгийн нэмэгдэл 20, тэгээд аймаг, орон нутаг нь өөрсдийн төсвийн чадавхаас хамаараад бас тодорхой хэмжээний нэмэгдэл өгөөд ингээд нэг үеэ бодоход бас гайгүй болсон.

Одоо манай орон нутгийн энэ хууль сахиулах байгууллагуудын алба хаагч нарын орон нутгийн нэмэгдлийг бас бид нарт сая орон нутгаар ажиллахад өгдөг байгаач ээ гэдэг асуудлыг бас дараагийн жилийн төсөвт суулгаж өгөх асуудлыг хөөцөлдөөрэй, хэлж ярьж өгөөрэй гэж хэлсэн.

Тэгээд энэ дээр манай Сангийн яам ямар байр суурьтай байгаа юм бол. Үүнийг нэг сонсчихье.

Д.Цогтбаатар: 1 минут нэмж авъя гэж үү? 1 дүгээр микрофон өгье.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж.

Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр төрийн албаны албан хаагчид маань 4 ангилалд хувааж байгаа.

Төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, төрийн улс төр, дээрээс нь төрийн тусгай алба.

Эдгээр албадууд маань аль аль нь өөр өөрийн гэсэн онцлогтой, нэмэгдэлтэй, өөр өөрийн гэсэн онцлог ажлын нөхцөл байдалтай, мөн үүрэг хариуцлагатай байгаад байдаг.

Тэгэхээр төрийн захиргааны албан хаагчид маань жишээ нь “зэрэг дэвийн нэмэгдэл” авдаг бол төрийн тусгай дээр энэ маань “цолны нэмэгдэл” гээд ороод ирчихдэг.

Нөгөө талдаа төрийн тусгай албаныхан “онцгой нөхцөлийн нэмэгдэл” гэж авдаг бол одоо “онцгой нөхцөл” гэдэг маань хилийн нөхцөл ч байдаг юм уу, эсвэл “алслагдсан бүсийн нэмэгдэл” гэдэг ойлголтоор явж байгаа юм. Хил дээр бол.

Нөгөө талдаа гэдэг юм төрийн захиргааны байгууллага дээр “орон нутгийн нэмэгдэл” гэж орж ирчхээд байгаа.

Тэгээд үүнийг нэг мөр ойлгохын тулд Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийг Засгийн газраас.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулъя. 1 дүгээр микрофон өгье.

М.Санжаадорж: Тийм.

Тэгэхээр энэ балансыг хадгалсан байдлаар. Мөн саяын Ц.Сандаг-Очир гишүүний гаргасан саналыг бид дэмжсэн байдлаар цаашдаа Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн

баталгааны тухай хуулийг Засгийн газар шинэчлэн боловсруулахаар ажлын хэсэг гараад өнгөрсөн оноос эхлээд ажиллаад байгаа юм.

Түүн дээр энэ цогц байдлаар орж ирээд, одоо бол аль нэг салбарыг бид илүү түрүүлж сугалж шийдэх биш, цогцоор нь энэ асуудлаа оруулж ирэхээр ажиллаж байгаа. Тийм. Баярлалаа. Хариулж дууслаа.

Д.Цогтбаатар: Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Сангийн сайд, Аудитын газрын дарга хоёр дараагийн Байнгын хороон дээр та хэд хүлээгдээд ирц нь бүрдчихсэн байгаад байх шиг байна. Тийм.

Эдийн засгийн байнгын хороо юу? Тийм. Тэгэхээр бусад нь байж байна.

Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү? Энэ хүмүүс явах болоогүй шүү. Зөвхөн хоёр сайдыг л явуулж байгаа.

Дараагийн Байнгын хорооныхоо хурлыг хүндэтгээд. Түүнээс манай гишүүдийн хэлэх үгийг яам, Тамгын газрын төлөөлөл нь байж байгаад сонсох ёстой.

Сангийн яамныхан яагаад гараад явчхав. Сангийн яамны Төрийн нарийныг нь дуудчих.

Тэндээ танилцуулгаа хийж л байна биз.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Би тэгвэл товчхон үг хэлнэ. Цаашдаа энэ асуудлыг ингээд хэлэлцэж байхад сая Сангийн сайд, Аудитын газрын дарга хоёрт манай ажлын албаныхан энэ юуг хүргэх хэрэгтэй.

Юу гэвэл ерөнхий төсвийнхөө гүйцэтгэлийг бүхэлд нь манай Байнгын хороон дээр хүрч ирж яриад байна. Аудитын газар ч, Сангийн яам ч.

Бид яг хариуцсан 18 байгууллагатай. Энэ 18 байгууллагынхаа л төсвийг, тэрний гүйцэтгэлийг бид ярьж байгаа юм.

Тэгээд энэ Байнгын хороон дээр бид тэр хаа байсан өөр байгууллагын юм уу, өөр төрийн өмчит аж ахуйн нэгж дээр гарсан зөрчил эд нарыг яриад байна шүү дээ. Энэ бол энэ Байнгын хороон дээр яригдах асуудал биш.

Тэгэхээр цаашдаа ийм төсвийн асуудлаа орж ирж ярих даа манай холбогдох байгууллагуудын төсвийн асуудлаа л ярьж байвал бид илүү ажил хэрэгч энэ асуудлуудаа хэлэлцэж байх боломжтой болно гэж үзэж байна.

Ингээд хэлэлцэж байгаа асуудлаар гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. /алх цохив/

Ингээд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023

оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулна.

Ингээд манай Байнгын хороо өнөөдөр хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууссан тул хуралдаан дууслаа.

Хуралдаанд оролцсон гишүүд, ажлын хэсгийн гишүүддээ талархал илэрхийлье. /алх цохив/

Хуралдаан 2 цаг 17 минут үргэлжилж, 14 цаг 05 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД